

3. Татварын тайлан гаргаагүй болон үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхлэхдээ бүртгэл хөтлөөгүй, эсхүл баримт хөтөлж бүрдүүлээгүй татвар төлөгч нь татварын албаны тогтоосон жишиг татварыг үгүйсгэх эрхгүй.
4. Жишгээр татвар ногдуулахдаа тухайн татвар төлөгчийг хариуцсан татварын байцаагч, хяналт шалгалтын байцаагч хамтран акт үйлдэж, нөхөн төлөх татварын хэмжээг тогтооно. Жишиг татварын актад тухайн татварын албаны дарга тус хуулийн 30-р зүйлд заасан үндэслэл буй эсэхийг хянаж, гарын үсэг зурна.»

#### Тайлбар

Энэхүү зүйл нь татвар төлөгч бүртгэл хөтлөөгүй, татварын тайлангаа гаргаагүй зэрэг шалтгаанаар татварын албаны даргын шийдвэрээр хийх жишгээр татвар ногдуулахтай холбогдсон заалт болно.

Эхний хэсгийн өөрчлөлтөөр «Жишиг татвар» гэдгийг тодорхой заан өгч, жишгээр ногдох татварын хэмжээг тогтоох асуудлыг шийдвэрлэх этгээд нь татварын албаны дарга болохыг тодорхойлохын зэрэгцээ жишиг татварт ашгийн төлөө аливаа үйлдвэрлэл, ажил үйлчилгээг хамруулж авч үзсэн болно.

2 дахь хэсгийн өөрчлөлт нь жишгээр татварын ногдлыг тодорхойлохдоо түүний үнэн зөв байдлыг хангах үүднээс татвар төлөгч нь өөрт байгаа баримтыг гаргаж өгөх үүрэгтэй болохыг тодорхойлон заасан болно.

3 дахь хэсгийн өөрчлөлт нь татвараа тайлагнаж, бүртгэл хөтлөөгүй, холбогдох баримт хөтөлж, бүрдүүлээгүй татвар төлөгчийн хувьд түүний энэхүү үйлдэл нь татварын хууль ноцтой зөрчсөн хэрэг болох тул татварын албаны жишгээр ногдуулсан татварыг татвар төлөгч нь эсэргүүцэх эрхгүй болохыг заасан болно.

4 дэх хэсгийн заалт нь татварын ногдлоор татвар ногдох орлого болон нөхөн татварыг тогтоох шийдвэрийг татварын албаны дарга гаргах тухай болон түүнтэй холбогдох хяналт шалгалтын акт боловсруулах тухай тодорхой зааж өгсөн болно.

#### **4.6 Процессийн хуулийн 22 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай**

Тус хуулийн 22-р зүйлийн «Төлөөгүй татварыг хураах» гэдэгт дараах заалт оруулах

«Эд хөрөнгө болон бусад орлогыг хурааж, бэлэн мөнгөөр тооцож авах»

#### Тайлбар

Энэхүү заалт нь татвар төлөгчийн эд хөрөнгө болон бусад орлогыг хураан авч, бэлэн мөнгөөр татварыг тооцон гаргуулж авахыг заасан болно.

#### **4.7 Процессийн хуулийн 23 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт өөрчлөлт оруулах тухай**

Тус хуулийн «Татварын төлбөрийг үл маргах журмаар төлүүлэх» гэсэн 23-р зүйлийн 1 дэх хэсгээс «шүүхийн шийдвэртэйгээс бусад» гэдгийг хасах

##### **Тайлбар**

Энэхүү заалтыг хэвээр нь орхивол, тухайлбал татвар төлөгчөөс өр нэхэмжилсэн аливаа шүүхэд хандагчийн нэхэмжлэлийн дагуу шүүх тухайн өрийг татвар төлөгчийн данснаас гаргуулан авах шийдвэр гаргасан тохиолдолд шүүхийн энэхүү шийдвэр гарахаас өмнө татварын алба татварын өртэй татвар төлөгчийн данснаас татварын төлбөр гаргуулан авах байлаа ч шүүхийн шийдвэрийг эн тэргүүнд гүйцэтгэх тул төсвийн орлогыг хугацаа алдалгүй бүрдүүлэх үүднээс дээрх заалтыг зайлшгүй хасах нь зүйтэй.

#### **4.8 Процессийн хуулийн 24 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай**

Тус хуулийн 24-р зүйлийг дараах маягаар өөрчлөх

1. Гарчгийн хэсэг дэх «...аас хураан авах» гэдгийг «... эд хөрөнгийг хураан авч бэлэн мөнгөөр тооцож хураах, ...» гэж өөрчлөх

##### **Тайлбар**

Энэхүү өөрчлөлтөөр татвар төлөгчийн эд хөрөнгө болон бусад орлогыг хураан авч, түүнийг бэлэн мөнгөд шилжүүлэн тооцож татвар хураан авахыг тодорхойлсон болно.

2. 1-р хэсгийг хасч дараах заалтыг нэмж оруулах

«Татвар төлөгч шинэ татварын ерөнхий хуулийн 11.1.1 болон 11.1.6, тус хуулийн 18.1.6, 18.2, 20.1-д заасан хугацаанд татвараа төлөөгүй, мөн тус хуулийн 23-р зүйлд заасны дагуу татварын төлбөрийг үл маргах журмаар гаргуулан авах боломжгүй тохиолдолд татварын алба нь шинэ татварын ерөнхий хуулийн 31.4-д заасны дагуу татвар төлөгчийн эд хөрөнгө, цалин болон бусад орлогоос бэлэн мөнгөөр тооцож гаргуулан авах»

##### **Тайлбар**

Өмнөх заалтаар татвар төлөгчийн эд хөрөнгө, цалин болон бусад орлогоос татварын төлбөр гаргуулан авахын тулд татварын алба нь

татвар төлөгчийн зөвшөөрлийг авах шаардлагатай байсан тул уг заалтыг хассан болно. Энэ нь төлөөгүй байгаа татварын өрийг барагдуулж хураан авах нь татварын албаны үндсэн эрхийн асуудал тул татварын алба нь энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ татвар төлөгчөөс ямар нэгэн зөвшөөрөл авах шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм. Энэхүү өөрчлөлт нь татварын орлого өсч, төсвийн орлогын нэмэгдэхэд нөлөөлөх болно.

### 3. 2 дахь хэсгийг хасч, дараах заалтыг нэмж оруулах

«Татварын төлбөрт авсан эд хөрөнгө болон бусад зүйлийн үнэлгээг хийхдээ хуульд заасан журмын дагуу явуулж, татварын төлбөрийг барагдуулна.»

#### Тайлбар

Татварын төлбөрт авсан эд хөрөнгө зэрэг нь бэлэн мөнгө биш тул түүнийг бэлэн мөнгөнд шилжүүлэн тооцож, үнэлгээ өгөх шаардлагатай бөгөөд энэхүү үнэлгээг хуульд заасан журмын дагуу явуулах тухай заав. Энэхүү өөрчлөлт нь 1-р хэсгийн заалтыг хассантай адил татварын орлого өсч, төсвийн орлого нэмэгдэхэд нөлөөлөх болно.

## 4.9 Процессийн хуулийн 26 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай

Тус хуулийн 26-р зүйлийн «Татвар төлөгчийн хөрөнгөнөөс гаргуулан авах» гэдгийг дараах маягаар өөрчлөх

### 1. 2-р хэсгийн 1 дэх заалтыг хасч, дараах заалтыг нэмж оруулах

«Татварын төлбөрт өгөх эд хөрөнгийн чанар, хэрэгцээ, элэгдсэн байдал, татвар төлөгчийн санал, орон нутгийн тухайн үеийн ханшийг харгалзан хураасан эд хөрөнгийг худалдах тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, худалдаа эхэлсэн өдрөөс 30 хоногийн дотор уг эд хөрөнгө борлогдохгүй тохиолдолд борлогдох үнээр нь борлуулж, орлогыг төсөвт оруулна.»

#### Тайлбар

Хуучин заалтаар аливаа эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдаалахаар байсныг нийтэд зарлан худалдсаны үндсэн дээр татварын алба өөрийн эрхийн хүрээнд шийдэх боломжтой болгож, худалдаж эхэлсэн өдрөөс 30 хоногийн дотор тухайн эд хөрөнгө борлогдохгүй тохиолдолд борлогдох үнээр нь борлуулж болохыг энэхүү өөрчлөлтөөр оруулсан болно.

### 2. 2-р хэсгийн 2 дахь заалтыг дараах маягаар өөрчлөх

«Татварын төлбөрт өгөх эд хөрөнгийг нийтэд зарлан худалдахад татвар төлөгч хүсвэл өөрөө, эсхүл өөрийн төлөөний этгээдийг байлцуулж болно» гэх

Тайлбар

Энэхүү өөрчлөлт нь дуудлага худалдаа гэдэг үгийн өөрчлөлттэй холбогдон гарах найруулгын өөрчлөлт болно.

3. 2 дахь хэсгийн 3-ыг хасах

Тайлбар

Өмнөх заалтаар дуудлага худалдаагаар борлогдоогүй эд хөрөнгийг татвар төлөгчид буцааж болох тухай заасан байсан ба үүнийг борлогдох үнээр нь нийтэд зарлан худалдаалах гэж өөрчлөх нь зүйтэй тул хасах хэрэгтэй.

4. 2 дахь зүйлийн 4 дэх хэсгийг дараах маягаар өөрчлөх

«Борлогдсон эд хөрөнгийн үнийн дүн татварын төлбөр, борлуулалтын зардлаас давсан тохиолдолд тус хуулийн 21-р зүйлийн дагуу шийдвэрлэж, түүний бүртгэлийг хөтлөх»

Тайлбар

Энэхүү өөрчлөлт нь дуудлага худалдааны хэлбэрийн өөрчлөлттэй уялдан гарсан өөрчлөлтийг тусгасан болно.

5. 2 дахь хэсгийн 5-ыг дараах маягаар өөрчлөх

«Борлогдсон эд хөрөнгийн үнийн дүн татварын төлбөрийн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд татвар төлөгч нь татвар төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй.»

Тайлбар

Энэхүү өөрчлөлт нь дуудлага худалдааны хэлбэрийн өөрчлөлттэй уялдан гарсан өөрчлөлтийг тусгасан болно.

6. 2 дахь хэсгийн 6-гийн дараа дараах заалтыг оруулах

«Нийтэд зарлан мэдээлсний үндсэн дээр худалдаалсан эд хөрөнгийн талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө. Татварын нэрийн дэлгүүрээр худалдан борлуулсан эд хөрөнгөөс орох орлогыг 3 хоногийн дотор тухайн татвар төлөгчийн нэр дээр төсөвт оруулна.»  
«Татварын төлбөрт авах эд хөрөнгийн борлуулах үнэ буурсан тохиолдолд тухайн татвар төлөгч үүнийг буцаан авч, татварын төлбөрийг бэлэн мөнгөөр хийж барагдуулна.»

Тайлбар

Энэхүү өөрчлөлт нь дуудлага худалдааны хэлбэрийн өөрчлөлттэй уялдан гарсан зохицуулалтын шинжтэй өөрчлөлт бөгөөд борлуулалтын орлогыг төсөвт төлөх хугацааг тодорхойлон заасан болно.

**4.10 Процессийн хуулийн 27 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай**

Хуулийн «татварын төлбөрийг гаргуулах тухай шүүхэд нэхэмжлэл гаргах» тухай 27-р зүйлийг дараах маягаар өөрчлөх

1. 1-р хэсэгт дараах заалтыг оруулах

«Шүүх нэхэмжлэлийг хүлээн аваад хуулийн заалтын дагуу шийдвэр гаргахдаа татварын албанаас төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон татвар, алданги, хүү, торгуулийг үндэслэлгүйгээр багасгах, хүчингүй болгож болохгүй »

Тайлбар

Энэ өөрчлөлт нь татварын албанаас гаргасан татварын төлбөрийг гаргуулах тухай нэхэмжлэлийн хариуд шүүх шийдвэр гаргахдаа татвар, алданги зэргийг үндэслэлгүйгээр багасгах, хүчингүй болгодог өнөөгийн практикаас урьдчилан сэргийлэх заалт бөгөөд ингэж болохгүй гэдгийг тодорхой болгож өгч байгаа юм.

2. 2-р хэсгийн «энэ хуулийн 24-р зүйлд заасны дагуу тохиролцсон боловч » гэсэн хэсгийг хасах

Тайлбар

Энэ нь уг хуулийн 24-р зүйлд өөрчлөлтөөр «татвар төлөгчтэй харилцан тохиролцох» болон «Татвар төлөгчөөс бичгээр зөвшөөрөл авах» шаардлагагүй болсонтой холбогдон гарах найруулгын өөрчлөлт болно.

**4.11 Процессийн хуулийн 31 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай**

Хуулийн 31-р зүйлийг дараах маягаар өөрчлөх

1. Уг зүйлийн гарчгийг «Татварын үйл ажиллагааны талаар банк, санхүүгийн байгууллагын хүлээх үүрэг» гэж өөрчлөх

Тайлбар

Энэхүү заалтад банк болон үнэт цаасны компани зэрэг санхүүгийн байгууллага ч хамрагдах тул дээрх өөрчлөлтийг хийв.

2. Уг зүйлийн 2-р хэсгийн «эхний ээлжинд шилжүүлэх ёстой төлбөр (Ажилчдад олгох цалингийн төлбөр)-өөс бусад тохиолдолд» гэсэн хэсгийг хасах

#### Тайлбар

Татвар төлөгчийн татварын өрийн төлбөрийг татвар төлөгчийн банкинд дахь данснаас гаргуулах тохиолдолд татвар төлөгчийн ажиллагсдад төлөх цалингаас илүү татварын өрийн төлбөрийг эхний ээлжинд тавих ёстой учир энэ хэсгийг хасах нь зүйтэй.

### **4.12 Процессийн хуулийн 35 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт өөрчлөлт оруулах тухай**

Хуулийн 35-р зүйлийн 2-р хэсгийн заалт тус бүрийг дараах маягаар өөрчлөх

1. «татварын байцаагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг тухайн байцаагчийн ажилладаг татварын албанд гаргана.»
2. «Татварын алба болон албаны даргын шийдвэртэй холбоотой гомдлыг тухайн татварын алба болон албаны даргад гаргана.»
3. «Уг зүйлийн 2 дахь хэсгийн 1 болон 2-т заасан гомдлыг барагдуулаагүй тохиолдолд татвар төлөгч түүний дээд шатны албанд гомдол гаргаж болно.»

#### Тайлбар

Энэ өөрчлөлт нь татварын байцаагч, татварын алба, албаны даргын шийдвэртэй холбоотой гомдол гаргах дарааллыг тодорхой болгож өгсөн бөгөөд татвар төлөгчид өөрийн хүссэнээр татварын ямар ч албанд гомдол гаргаж болох тухай өмнөх заалтыг татварын албаны удирдлагын хүрээнд асуудлыг шийдэх, үр дүнг сайжруулах үүднээс хасах саналтай байна.

### **4.13 Процессийн хуулийн 36 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай**

Хуулийн 36-р зүйлийг дараах маягаар өөрчлөх

«Татвар төлөгч уг хуулийн 35-р зүйлийн 2, 3-т заасан дарааллын дагуу гомдлоо гаргасан боловч түүнийг барагдуулаагүй тохиолдолд шүүхэд гомдол гаргах эрхтэй. Мөн татвар төлөгчтэй холбоотой шалтгааны улмаас хуулиар тогтоосон татварын тайлан гаргах хугацаа, хуулиар тогтоосон татвар төлөх хугацаа зэрэг татвартай холбоотой хуулийн заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд шүүхэд гомдол гаргах эрхгүй.»

#### Тайлбар

Энэ өөрчлөлтийн эхний хэсэг нь татвар төлөгчийн шүүхэд гомдол гаргах шат дамжлагыг тодорхой болгон өгч байна. Урьд нь хэзээ ч

хамаагүй шүүхэд гомдол гаргаж болдог байсныг энэ хуулийн 35-р зүйлд заасан шат дамжлагын дараа л шүүхэд хандаж болно гэдгийг зааж өгсөн.

Сүүлийн хэсгийн хувьд татвар төлөгч татварын хуулийн заалтыг өөрөөс шалтгаалах учир шалтгааны улмаас сахин биелүүлж чадаагүй нөхцөлд ч шүүхэд хандаж болохыг хүлээн зөвшөөрөх юм бол татварын хуулийн хэрэгжилт хангалтгүй болохын зэрэгцээ татвар төлөгчийн эрхийг хэтрүүлэх байдлыг хүлээн зөвшөөрсөн хэрэг болох тул энэхүү заалтыг бий болгосон болно.

#### **4.14 Процессийн хуулийн 37 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай**

Хуулийн 37-р зүйлийг дараах байдлаар өөрчлөх

1. Энэ зүйлийн 1 дэх хэсгийг «татварын алба, татварын байцаагч татварын өртэй татвар төлөгчийн эд хөрөнгө, мөнгө, бичиг баримт, бүртгэлийн дэвтэр, оршин суугаа газар, агуулахыг (хойшид хөрөнгө гэх) дор дурдсан шалтгаан болон цаг хугацаагаар барьцаанд авч эсвэл битүүмжилж, хураан авч болно.» гэх

Тайлбар

Энэхүү өөрчлөлт нь татвар төлөгчийн хөрөнгийг барьцаанд авах болон битүүмжлэх, хураах эрхийг хүлээн зөвшөөрсөн заалт бөгөөд эдгээр эрхийг татвар төлөгчид татварын өртэй тохиолдолд хэрэгжүүлэх талаар тодотгож өгсөн.

2. Уг зүйлийн 1 дүгээр хэсгийн 1 дэх заалтыг «татвар төлөгч татварын байгууллагын тогтоосон хугацаанд татвар төлөлгүй удаашруулсан тохиолдолд» гэж өөрчлөх

Тайлбар

Энэхүү өөрчлөлт нь уг зүйлийн 1 дүгээр хэсгийн заалтанд хамаарах нэг тохиолдол болох татварын байгууллагын заасан хугацаанд татвараа цаг хугацаанд төлөөгүй тохиолдлыг тодорхойлон зааж өгсөн болно.

3. Уг зүйлийн 1 дүгээр хэсгийн 2 дахь заалтыг «татварын хяналт шалгалт, тооллого, ажлын зураг авалт хийхдээ эдгээр шалгалтыг хийж дүгнэлт гаргах хүртэлх хугацаа, эсвэл шийдвэр гарах хүртэлх хугацаа» гэж өөрчлөх хэрэгтэй.

Тайлбар

Энэхүү өөрчлөлтөөр уг зүйлийн 1 дүгээр хэсэгт хамаарах нэг тохиолдол болох татварын хяналт шалгалт, тооллого, ажлын зураг авалтыг явуулж эцсийн дүгнэлт гаргах хүртэлх хугацаа, эсвэл шийдвэр гарах хүртэлх хугацааг тодорхойлон зааж өгсөн болно.

4. Уг зүйлийн 1-р хэсгийн 3 дахь заалтыг «татвар төлөгч татварын хуулинд заасан болон татварын байгууллагын тогтоосон хугацаанд татвар төлөөгүй тохиолдолд болон төлөхгүй магадлал байх тохиолдолд» гэж өөрчлөх хэрэгтэй.

#### Тайлбар

Энэхүү өөрчлөлтөөр уг зүйлийн 1-р хэсэгт хамаарах тохиолдол болох татварын хуулинд заасан болон татварын байгууллагын тогтоосон хугацаанд татвараа сайн дураар төлөөгүй тохиолдол болон төлөхгүй байх магадлалтай тохиолдлыг онцлон заасан болно.

5. Тус зүйлийн 2 дахь хэсгийн дараа дараах заалтыг оруулах

#### Тайлбар

« Татварын алба үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилж барьцаанд авах эсвэл хурааж авахдаа үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт мэдэгдэнэ. »

« Битүүмжилсэн эсвэл барьцаанд авсан эд хөрөнгийг тухайн эзэмшигчийн байнгын хамгаалалд байлгана»

« Татварын алба битүүмжилж барьцаалах, эсвэл хурааж авсан эд хөрөнгийн талаар 60 хоногийн дотор дараах арга хэмжээг авна:

1. Татварын алба татвар төлөгч татварын өрөө бэлэн мөнгөөр төлөх боломжгүй үед битүүмжилж эсвэл барьцаалсан эд хөрөнгийг хурааж аван хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан худалдана. Мөн хурааж авсан эд хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.
2. Тус хуулийн 37-р зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь дэд хэсэгт заасан хугацаа дууссан тохиолдолд битүүмжилэн барьцаалж эсвэл хурааж авсан авсан эд хөрөнгийг татвар төлөгчид буцаан олгоно.
3. Тус хуулийн 37-р зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь дэд хэсэгт заасан хугацаа дуусах үеэс, мөн татвар төлөхийг шаардсан нэхэмжлэл гарсны дараа сайн дураар татвараа төлөөгүй нь тогтоогдсон үеэс битүүмжилэн барьцаалж, эсвэл хурааж авсан эд хөрөнгийг худалдах эрх үүснэ.»

#### Тайлбар

Тухайн эзэмшигчийн эд хөрөнгийн бүртгэлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар хариуцаж буй учир үл хөдлөх эд хөрөнгийн арилжааны баталгаат байдлыг хангах үүднээс тухайн газарт мэдэгдэж байхаар заав.

Битүүмжилж барьцаалсан эд хөрөнгийг буцаан олгож болох бөгөөд энэ тохиолдолд тухайн эзэмшигчийн байнгын хамгаалал дор хариуцуулан өгөхөөр заав.



Энэхүү өөрчлөлтөөр битүүмжилж барьцаалсан, эсвэл хурааж авсан эд хөрөнгөнд татварын албанаас авах арга хэмжээ болон түүний хугацааг заасан болно.

**4.15 Процессийн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дугаар хэсэгт өөрчлөлт оруулах тухай**

Хуулийн 39-р зүйлийн 2 дахь хэсгийн «татварын албаны удирдах дээд байгууллага, шүүх» гэснийг «тухайн татварын алба» гэж өөрчлөхийн хамт тус хэсгийн дараа «тухайн гомдлыг хүлээн аваагүй тохиолдолд татварын албаны удирдах дээд байгууллагад гомдол гаргаж болно. Татварын албаны удирдах дээд байгууллага уг гомдлыг хүлээн аваагүй тохиолдолд л сая шүүхэд гомдол гаргаж болно.» гэж нэмж оруулах нь зүйтэй.

Тайлбар

Энэхүү өөрчлөлтөөр татвар төлөгчийн зүгээс татварын алба болон шүүхэд гомдол гаргах журмыг тодотгож заасан бөгөөд шууд шүүхэд ханддаг байсан бол энэ өөрчлөлтөөр татвар төлөгч зөвхөн эцсийн шатанд шүүхэд хандахаар болгосон юм.

**4.16 Процессийн хуулийн 40 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай**

Хуулийн 40-р зүйлийн «хүлээлгэх хариуцлага»-т заасан торгуулийн дээд хэмжээг одоогийнхоос 10 дахин нэмэх нь зүйтэй.

Тайлбар

Торгуулийн хэмжээ бага байх тохиолдолд санаатайгаар уг үйлдлийг хийх боломжийг татвар төлөгчдөд олгох тул түүний дээд хэмжээг нэлээд өндөр болгох шаардлагатай.

## Бүлэг 5



## **5. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн өөрчлөлттэй холбогдох санал**

### **5.1. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тогтмол татвар нэвтрүүлэх тухай**

Нийгмийн ашгаас хүртдэг хэрнээ татварын ямар ч үүрэг хүлээдэггүй, өөрөөр хэлбэл, алдагдалтай ажиллан татвар төлдөггүй аж ахуйн нэгж, байгууллагад ч гэсэн тохирсон хэмжээний татварын ачаа үүрүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа тул байнгын төсвийн орлогын эх үүсвэр болох аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тогтмол татварын тогтолцоог шинээр нэвтрүүлэх талаар судалгааны хэсгээс урьд өмнө санал гаргаж байсан.

Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны тогтмол татвар нь жишиг татварын нэг төрөл бөгөөд уг татварыг ногдуулахдаа ашигтай эсвэл алдагдалтай ажиллаж байгаа эсэхээс үл хамааран тогтмол хэмжээгээр татвар ногдуулах (жилийн 100000 төгрөг гэх мэт), эсхүл үйл ажиллагааны цар хүрээнд нь тохируулан борлуулалтын орлогын дүн, эсвэл нийт хөрөнгийн дүнгийн тодорхой хувиар тооцсон татварын аль өндрөөр нь аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тогтмол татварыг ногдуулах системийг нэвтрүүлэх хэрэгтэй.

Татвар ногдуулах энэ арга нь шинэлэг бөгөөд үр дүн сайтай тул татвар ногдуулалтын уг аргыг хэрэгжүүлснээр татварын орлого нэмэгдээд зогсохгүй татварын албаны ажлын ачаалал багасахад шууд нөлөөлөхийн зэрэгцээ татварын албаны өртөг зардлыг багасгах нь дамжиггүй юм.

Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тогтмол татварын энэхүү аргаар татвар ногдуулахдаа жишээлбэл, 2 шатлал гарган жилийн 10,000,000₮-өөс дээш татвар ногдох орлоготой аж ахуйн нэгжийн тухайд өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан борлуулалтын орлогын 3 хувь, цалингийн зардлын 5 хувь хоёрын аль ихээр нь; 10,000,000 төгрөгөөс бага татвар ногдох орлоготой жижиг дунд үйлдвэрийн хувьд дээрх борлуулалтын орлогын 3 хувь болон 100000 төгрөгийн аль өндрөөр тогтмол татварыг тооцох замаар татварын ачаалалыг хөнгөлөх ба ингэхдээ тайлант хугацааны эцэст сайн татвар төлдөг аж ахуйн нэгж, байгууллагын татварын ачааллыг нэмэгдүүлэхгүй байх үүднээс улирлын болон жилийн эцсийн тайлангаар ногдуулсан аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хэмжээ үйл ажиллагааны тогтмол татварын дүнгээс их байвал зөвхөн аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хэмжээнээс илү гарсан дүнгээр үйл ажиллагааны тогтмол татварыг тооцож ногдуулах хэрэгтэй.

Энэ системийг нэвтрүүлснээр татвар төлөгчийн зүгээс хүчтэй эсэргүүцэлтэй тулгарна гэж үзсэн тохиолдолд татварын хувь хэмжээг бууруулах арга хэмжээ авч болох юм. Татварын хувийг ийнхүү бууруулснаар төсвийн орлогын хэмжээ бага зэрэг буурах хэдий ч хойшид

төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөлөөтэй ба төсвийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж байгаа бол уг тогтмол татварын системийг ойрын хугацаанд нэвтрүүлэх хэрэгтэй. Түүнчлэн энэхүү системийг нэвтрүүлснээр өмнө дурьдаж байсанчлан алдагдалтай аж ахуйн нэгж, байгууллага ч гэсэн тодорхой хэмжээгээр аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар төлдөг болох тул аж ахуйн нэгж, байгууллагын албан татвараас төсөвт орох тогтмол орлогын хэмжээ нэмэгдэхэд шууд нөлөөлөх нь дамжиггүй юм.

Дараах жишээн дээр төсвийн орлого хэрхэн нэмэгдэж болохыг тооцож үзье:

1999 оны байдлаар бүртгэгдсэн аж ахуйн нэгжийн тоо 16320, үүнээс татварын тайлангаа гаргасан аж ахуйн нэгжийн тоо 14354, 1999 оны аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хэмжээг бүх аж ахуйн нэгж байгууллагад 3 % -р ногдуулсан гэж үзвэл аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тогтмол татварын хэмжээг барагцаагаар тооцоход доорх дүн гарч байна:

- ① 1999 оны аж ахуйн нэгж, байгууллагын борлуулалтын орлогын нийт хэмжээ 891,436,847,480 Тг
- ② 1999 оны аж ахуйн нэгж, байгууллагын цалингийн нийт хэмжээ 99,835,384,220 Тг
- ③ 1999 оны аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хэмжээ 24,633,341,000 Тг
- ④ Борлуулалтын орлогын 3% =  $1 \cdot 3\% = 26,743,105,424$ Тг
- ⑤ Аж ахуйн нэгж, байгууллагын тогтмол татвар = 4 - аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хэмжээ =  $2,109,764,424$ Тг
- ⑥ Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны тогтмол татварын өссөн цэвэр хэмжээ  $(16320 \text{ компани} - 14354 \text{ компани}) \cdot 100000 \text{ төг} = 196,600,000 \text{ төг}$
- ⑦ 100000 төгрөгөөр тооцсон аж ахуйн үйл ажиллагааны тогтмол татварын хэмжээ  $(16320 \text{ компани} \cdot 100000) = 1,632,000,000 \text{ төг}$

Дээр дурьдсанчлан 1999 оны татвар төлөгчдийн тоонд тулгуурлан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тогтмол татварын дүнг тооцвол 5,6 хоёрын нийлбэрээр 2,306,364,424 төгрөг болж байна.

## Бүлэг 6



## 6. Хүн амын орлогын албан татварын хуулийн өөрчлөлттэй холбогдох санал

### 6.1 Хүн амын орлогын албан татварын өнөөгийн байдал

1997-1999 онд төсвийн орлогын гүйцэтгэлд хүн амын орлогын албан татварын эзлэх хувь болон түүний бүтцийг үзүүлбэл дараах байдалтай байна:

Хүснэгт 6-1 ХАОАТ-ын төсвийн орлогод эзлэх хувь:

Нэгж: 1000 Төг

	1999	1999	1997
(1) Нийт орлого	123,176,204	103,305,112	115,040,583
(2) ХАОАТ	12,564,271	9,954,158	7,703,386
(2)/(1)	10,2%	9,6%	6,7%
Бүртгүүлсэн	229,292 хүн (100%)	76,925 хүн (100%)	79,458 хүн (100%)
Тайлан гаргасан	20,114 хүн (8%)	13,849 хүн (18%)	4,176 хүн (5.3%)

Хүснэгт 6-2: ХАОАТ-ын бүтэц (хаалтан доторхи % нь хүснэгт 2-ын ②-т эзлэх хувийг харуулна)

нэгж: ₮

	1999	1998	1997
Суутгал-1	10,544,329 (83.9%)	8,129,366 (81.7%)	6,709,478 (87.1%)
Патент*	1,014,911 (8.1%)	849,670 (8.5%)	291,242 (3.8%)
Мал	693,329 (5.5%)	588,316 (5.9%)	438,741 (5.7%)
ХЭАА	289,913 (2.3%)	233,044 (2.4%)	130,644 (1.7%)
Бусад суутгал	21,790 (0.2%)	153,762 (1.5%)	-
Хадгаламжийн хүү	-	-	133,281 (1.7%)

Жич: Патентын татвар нь ХЭАА-ийн дотороос орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэдийн орлогын албан татварын хуулинд хамрагдах иргэдэд орон нутаг, ажил үйлчилгээний төрлөөр ногдуулсан тогтмол татвар юм.

Үүнээс үзэхэд ХАОАТ-ын төсвийн орлогод эзлэх хувь жил бүр өсөх хандлагатай байгаа боловч 1999 оны гүйцэтгэлээр 10.2% болж өссөн боловч НӨАТ (27%) болон ААНОАТ (20%) –тай харьцуулахад тийм ч өндөр биш юм. Японы жишээг аваад үзэхэд 1999 оны санхүүгийн жилд төсвийн татварын орлогод эзлэх ХАОАТ-ын (суутгал, тайланг оролцуулаад) хувь 38.4 % байсан бол худалдааны татвар 20.3%, ААНОАТ 20.4%-ийг тус тус эзэлсэн байна.



Мөн ХАОАТ-ын 1999 оны гүйцэтгэлийг бүтцээр нь авч үзэхэд Суутган-1-ээр төлдөг татвар нь нийт ХАОАТ-ын дүнд маш өндөр хувь (83.9%)-ийг эзэлж байгааг харуулсан бөгөөд түүний дараа патентын татвар 8.1%, малын татвар 5.5%, ХЭАА 2.3%, бусад татвар 0.2%-ийг тус тус эзэлж байна.

ХАОАТ-ын суутгалаас бусад татварын төсвийн орлогод эзлэх хувийн жин бөгөөд тайлан гаргагчдын тоо татвар төлөгчөөр бүртгүүлсэн хүмүүсийн тооноос хэт бага (1999 оны гүйцэтгэлээр зөвхөн 8.8%-ийг эзэлж байна) байгаа нь хүн амын орлого багаас болоод татвар ногдуулах орлого бага байдгаас тайлан үл гаргагчид их байна уу, эсвэл энэ нь татвар ногдуулалт, татвар хураалтын үйл ажиллагааны дутагдалтай холбоотой байна уу гэдгийг судалж үзэх шаардлагатай байна.

Доор ХАОАТ-ын тогтолцоотой болон хэрэгжүүлэхтэй холбогдолтой асуудлуудыг тал талаас нь авч үзлээ.

## 6.2 ХАОАТ-ын бүтэц

ХАОАТ-ын хуулийг 1993 онд баталсны дараа хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулан өнөө хүртэл мөрдөж байгаа бөгөөд хууль нь 12 зүйлээс бүрдэж байна.

### 6.2.1 Татвар ногдуулах орлого

Татвар ногдуулах орлогын тухайд гэвэл орлогоос татвар суутгах тухай тодорхой зааж татвараас чөлөөлөх тухай (4-р зүйлийн 1) заалт оруулсны зэрэгцээ татвараас чөлөөлөх орлогоос бусад орлогод татвар ногдуулна гэсэн нь зарчмын хувьд бүх төрлийн эдийн засгийн орлогод татвар ногдуулна гэсэн санааг агуулж байна.

Энэ нь Япон улсын орлогын татварын хуультай адил татварын суутгалыг татварын ачаалал даах чадвараас хамаарч 10 төрөлд ангилж төрөл тус бүрийн татвар ногдуулах орлогыг тооцоолох аргыг заасан байдгаас ялгаатай боловч бүх л төрлийн эдийн засгийн орлогод татвар ногдуулах зарчим нь ижил юм.

### 6.2.2. Татвар ногдох орлогыг тооцоолох арга ба татвар төлөх аргаарх ангилал

Жил бүрийн орлогоосоо зардлаа хасч татвар ногдох орлогоо өөрөө тодорхойлж, хуулийн 7-р зүйлийн 1-д заасан хувь хэмжээгээр татвар төлөх хэмжээг тогтоон тайлан гаргадаг аргаас гадна орлогын хэмжээг тусгай тогтоосон хувь (8-р зүйл бүх заалт)-иар үржүүлж татварыг суутгадаг хоёр үндсэн аргыг хэрэглэж байна.

Өөрөө татвараа тодорхойлон тайлан гаргахад ч гэсэн төсвийн орлогын жигд байдлыг хангахын үүднээс сар бүр эсвэл улирал бүр татварын хэмжээг тооцон төлөөд жилийн эцсээр нэгтгэж тооцно.

Татвар ногдуулах орлогыг тооцоолох болон төлөх аргаар нь ангилж авч үзье.

- 1) Татварын үндсэн хувь хэмжээ (15%-40%-ын хоёр шатлалтай өсөн нэмэгдэх шатлал)-ээр татвараа тодорхойлох
  - ① Аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллаж буй үндсэн ажилтны цалин, бусад орлого (4-р зүйлийн 1-1а)) Ажил олгогч сар бүр цалингаас суутган дараа сарын 10-ны дотор тушаан, жилийн эцэст татварын тайланг гаргаж дараа оны 2 сарын 10-ны дотор татварын албанд ирүүлнэ.
  - ② Үндсэн ажлаас гадуур бусад аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр авсан цалин бусад орлого (4-р зүйлийн 1-1б) Олгохдоо 10%-ийг суутган жилийн эцэст татварын тооцоо хийн тайланг дээрхтэй адил гаргана.
  - ③ Тэтгэвэр, тэтгэмж (4-р зүйлийн 1-1.б) Жилийн эцэст татварын тооцоо хийж, тайланг (1)-тэй адил гаргана.

- ④ ХЭАА-н орлого (4-р зүйлийн 1-3)  
Татвар ноогдуулах орлогыг тооцохдоо орлогын дүнгээс бараа материал худалдан авсан үнийг хасч тооцох ба улирал бүр төлөх татварыг тооцож дараа улирлын эхний сарын 15-ны дотор төлнө. Жилийн эцсээр тооцоо хийж тайланг (1)-тэй адил гаргана. Мөн гахай, тахиа, туулай, зөгий үржүүлэгчид болон тэдгээртэй адилтгах аж ахуй эрхлэгчид өөрсдөө татвараа тодорхойлно (5-р зүйлийн 2 в).
  - ⑤ Хувь хүн аж ахуйн нэгж байгууллагад бараа материал худалдсан тохиолдолд аж ахуйн нэгж нь худалдан авсан үнийн дүнгийн 3 хувиар татвар ноогдуулж суутгана. Суутгасан татварыг ХЭАА-н жилийн эцсийн татварын тооцоонд оруулан дараа жилд татварын тайлангаа татварын албанд гаргаж өгнө.
  - ⑥ Хөрөнгө түрээслүүлсний орлого (4-р зүйлийн 1-5.в)  
Татвар ноогдуулах орлогыг тооцохдоо орлогын дүнгээс гарсан зардлыг хасч тооцох бөгөөд улирал бүр татварын тооцоог хийж дараа улирлын эхний сарын 15-ны дотор төлнө. Жилийн эцсийн тооцоо, тайлан гаргах нь ①-тэй адил.
  - ⑦ Энэ хуульд албан татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад орлого (4-р зүйлийн 9)  
Татвар ноогдуулах орлого нь нийт орлогын дүн байна. Жилийн эцэст тооцоо хийнэ. Тайлан гаргалт нь ①-тэй адил.
- 2) Албан татвар тусгайлан ногдуулах хувь хэмжээ (2%, 10%, 15%)-иар татвар ногдуулах
- ① Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого болон түүнтэй адилтгах орлого (4-р зүйлийн 1.5.а)  
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого нь татвар ноогдуулах орлого болох бөгөөд (5-р зүйлийн 3а) үүнд 2%-иар татвар ногдуулж (8-р зүйлийн 3) дараагийн улирлын эхний сарын 15-ны дотор төлнө (10-р зүйлийн 7.2). Тайланг татвар төлснөөс хойш 15 хоногийн дотор татварын албанд ирүүлнэ.
  - ② Хувьцаа, үнэт цаас, хувьцааны ноогдол ашиг хүртэгчийн орлого (4-р зүйлийн 1-5). Ноогдол ашиг, хувь хүртэгчийн орлогод 15% (8-р зүйлийн 4)-иар татвар ноогдуулж, суутгана. Татварыг 3 өдрийн дотор төсөвт оруулна (10-р зүйлийн 6). Жилийн болон улирлын тайланг орлогыг олгосноос хойш 15 хоногийн дотор татварын албанд ирүүлнэ (11-р зүйлийн 5). Хувьцаа, үнэт цаас, хувьцааны ноогдол ашиг хүртэгчийн орлогод 2003 оны 1 сарын 1-нээс эхлэн татвар ногдуулна.
  - ③ Зохиогчийн эрх, программ хангамж, патент ашигласны төлбөр зэргээс олсон орлого (4-р зүйлийн 1-5г). Эрхийн шимтгэлийн орлого (5-р зүйлийн 3е)-д 10% (8-р зүйлийн 8)-иар татвар ноогдуулж суутган 3 хоногийн дотор төсөвт оруулна (10-р зүйлийн 6).
  - ④ Зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлого (4-р зүйлийн 1-5д). Зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлогын дүнд 15% (8-р зүйлийн 4)-иар татвар ноогдуулж суутган 3 хоногийн

дотор төсөвт оруулна (10-р зүйлийн 6). Зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлогод 2003 оны 1 сарын 1-нээс эхлэн татвар ногдуулна.

- ⑤ Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл оновчтой санал гаргагч, загвар зохион бүтээгчийн шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого (4-р зүйлийн 1-6). Орлогын дүн (5-р зүйлийн 5)-д 15% (8-р зүйлийн 1)-иар татвар ноогдуулж суутган 3 хоногийн дотор төсөвт оруулна (10-р зүйлийн 5).
- ⑥ Урлагийн тоглолт, биеийн тамир, спортын уралдаан тэмцээний шагнал (4-р зүйлийн 1-7). Орлогын дүн (5-р зүйлийн 6)-д 10% (8-р зүйлийн 7)-иар татвар ноогдуулж суутган 3 хоногийн дотор төсөвт оруулна (10-р зүйлийн 5).
- ⑦ Бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалааны хонжворын орлого (4-р зүйлийн 1-8). Орлогын дүн (5-р зүйлийн 7)-д 10% (8-р зүйлийн 7)-иар татвар ноогдуулж суутган 3 хоногийн дотор төсөвт оруулна (11-р зүйлийн 5).
- ⑧ Гадаад оронд эмнэлэг болон урлаг, уран сайхан, эрдэм шинжилгээ, сурталчилгаа зэрэг оюуны үйлчилгээ явуулсан иргэний орлогод монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол (8-р зүйлийн 9) 10%-ийн татвар ноогдуулж суутган, 3 хоногийн дотор төсөвт оруулна (11-р зүйлийн 5).
- ⑨ Татвар төлөгч татвар төлөгчийн дугаараа орлого олгогчид тэмдэглүүлээгүй бол (8-р зүйлийн 10) энэ хуулийн 8-р зүйлийн 1, 4, 6,7,8-д заасан орлогод энэ хуулийн 8-р зүйлд заасан 20%-иар татвар ноогдуулна.
- ⑩ Түр оршин суугч (Монгол улсад жилд 183 хоногоос доош хугацаагаар оршин суугч гадаадын иргэн болон харьяалалгүй этгээд) болон байнга оршин суугч (Монгол улсад жилд 183 хоногоос дээш хугацаагаар оршин суугч этгээд) болон түр оршин суугч этгээдээс бусад этгээдийн энэ хуулийн 8-р зүйлд, 4-р зүйлийн 1 дэхь хэсгийн 5 дахь заалтын в-д заасан орлогод 20%-иар татвар ноогдуулна.

3) Малын орлогын албан татвар (6-р зүйл)

Мал бүхий иргэдэд албан татвар ногдуулахдаа малын тоог богод шилжүүлэн тооцно. Үхэр, адуу, тэмээг 5 хонь, ямааг 1.5 хонь гэж шилжүүлэн тооцно. Тухайн жилийн мал бүхий иргэдийн орлогыг жилийн эцэст тоологдсон малын тоонд үндэслэн тогтооно.

Мөн малын тоо толгойнд ногдох татварын хэмжээг 3 бүсээр ялгаатай тогтоосон (8зүйлийн 5).

4) Орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч (7-р зүйлийн 4)

Орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ эрхлэгчдэд ногдуулах татварын хэмжээг засгийн газрын саналаар УИХ-ас тогтооно. Энэ заалтын дагуу орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдийн орлогын албан татварын хууль батлагдан (1997 оны 5 сарын 1), энэ хуульд хамрагдах хувиараа ажил ажил үйлчилгээ эрхлэгчид нь орлого зардлаасаа хамаарахгүйгээр, ажил үйлчилгээний

төрөл, орон нутгаас нь хамааран тогтоосон татварыг (патентын төлбөр) сар бүр төлнө.

Мөн үүнээс гадна энэ хуулийн 5-р зүйлд «татвар ногдуулах орлогоо тодорхойлоогүй буюу тодорхойлох боломжгүй бол байгал цаг уур, зах зээлийн нөхцөл, ижил үйлдвэрлэгчтэй харьцуулсан жишгээр татварын алба тодорхойлно гэж заасан бөгөөд энэ нь татварын алба жишгээр татвар ногдуулж болохыг хүлээн зөвшөөрсөн заалт юм.

Одоо мөрдөгдөж буй ХАОАТ-ын хуулинд тусгагдсан татвар ногдуулах зарчим, тооцоолох арга, татвар төлөлтийн тухай товч өгүүллээ. Одоо татварын тогтолцоо, хэрэгжүүлэлттэй холбоотой тулгамдсан асуудлыг авч үзье.

### **6.3 ХАОАТ-ын хуулин дахь татварын тогтолцоо болон хэрэгжүүлэлттэй холбоотой тулгамдсан асуудал**

#### **6.3.1 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээний албан татварын тухай**

Хувиараа ажил үйлчилгээ эрхэлж буй хүмүүсээс орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдэд ХАОАТ-ын хуулинд заасан орлого зарлагын тооцоон дээр үндэслэн татвар ногдуулах зарчмаар бус «Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдийн албан татварын хууль»-ийн дагуу зөвхөн тогтоосон патентын төлбөр ногдуулж байна. Энэ нь орлогын их багаас хамааралгүйгээр тогтоосон нэг хэмжээгээр татвар төлснөөр татварын харилцаа дуусгавар болж байна гэсэн үг бөгөөд татварын тэгш байх зарчимд харшилж байна. Энд хамрагдаж буй ажил үйлчилгээний төрлийг авч үзэхэд зорчигч тээвэр, үйлдвэрлэл, худалдаа, эмнэлэг, үйлчилгээ зэрэг аж үйлдвэрийн үндсэн салбаруудын зарим хэсгүүд нь хамрагдаж байна. Эдгээрийн орлогын их багаас нь хамаарахгүйгээр тогтоосон нэг хэмжээгээр татвар ногдуулж байгаа нь татварын тогтолцоонд тэгш бус байдлыг бий болгож байна.

Үнэн хэрэг дээр эдгээр ажил үйлчилгээ эрхлэгчдийн орлогын дүнгээс шууд болон шууд бус зардлыг нь хасч тооцсон үнэн бодит орлогод нь үндэслэн татвар ногдуулах ёстой бөгөөд одоогийн байдлаар (1) татвар төлөгчдийн татвар төлөлтийн ухамсар муу, өөрсдөө татвараа үнэн зөвөөр тодорхойлно гэдэгт найдахад хэцүү, (2) бүртгэл хөтөлж дадаагүй, татвар төлөгчдийн ихэнх нь орлого зарлагаа тэмдэглэсний үндсэн дээр орлогоо үнэн зөв тодорхойлон татвараа тооцох дадал төлөвшөөгүй, (3) үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн ихэнх нь бэлэн мөнгөөр гүйлгээ хийж байгаа нь татварын албанаас татвар ногдуулалтыг хийхэд хүндрэлтэй байдаг, (4) хүн хүчний дутагдалтай байдлаас болоод татварын албанаас эдгээр хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчдэд тавих татварын хяналт шалгалтыг бүрэн дүүрэн хийж чадахгүй байгаа байдал, (5) татварын алба татварын тэгш бус байдлыг золиослон зардал их шаардахгүй, тодорхой хэмжээний татварын орлогыг хадгалах гэсэн шалтгаануудаас болж энэ аргыг хэрэглэсээр байгаа юм.

Мөн одоогийн мөрдөж буй ажил үйлчилгээний ангиллын алинд нь ч ороогүй шинэ ажил үйлчилгээ бий болох, зарим төрлийн ажил үйлчилгээний орлого ихээр нэмэгдэх зэргээр татварын ачааллын тэнцвэрт байдал алдагдах зэрэг муу уршиг гарч байна.

Иймээс одоо шууд энэ тогтолцоог бүрэн халах нь хүндрэлтэй байгаа гэсэн ч аль болох хурдан ХАОАТ-ын хуулиар татвар ногдуулдаг тогтолцоонд шилжих нь зүйтэй. Ингэснээр татварын орлогыг нэмэгдүүлэхээр барахгүй хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчдийг НӨТ-д хамруулах боломжтой болох юм.

Мөн орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдэд ногдуулах татвар, түүнийг шйдвэрлэх арга замын тухай 3-р бүлгийн 5-д тодорхой авч үзсэн.

### **6.3.2. Мал бүхий иргэдийн албан татварын тухай**

Уг хуулийн 6-р зүйлд хувийн мал бүхий иргэний албан татвар ногдуулах малын толгойн тоог хонин толгойд шилжүүлэн тодорхойлж татварын тооцоонд үхэр, адуу, тэмээ тус бүрийг 5 хонь, 1 ямааг 1.5 хонь гэсэн тооцоог үндэслэн ногдуулахаар заасан байна.

Гэвч сүүлийн үед ноолуур зэрэг өндөр үнэтэй түүхий эдээ худалдаж өндөр ашиг олж байгааг бодолцож үзэх юм бол малын албан татварыг зарчмын хувьд тоо толгойгоор нь ногдуулахын зэрэгцээ ноолуураас олох орлогыг малын албан татвараас тусад нь татвар ногдуулах орлого болгон оруулаад (Үүнтэй холбоотой тодорхой шийдвэрийг ҮТЕГ-ын дарга гаргах) үйл ажиллагааны орлого зардалд нь үндэслэн татвар ногдуулах орлогыг тооцоолох тухай заалтыг шинээр оруулах хэрэгтэй.

Ингэснээр зөвхөн малын тоо толгойгоор бага хэмжээний татвар ногдуулснаар хязгаарлагддаг байдал алга болж эцсийн дүндээ татварын орлого нэмэгдэхийн зэрэгцээ өндөр үнэтэй түүхий эд борлуулдаг иргэд, борлуулдаггүй иргэд хоорондын татвар ногдуулалтын тэгш бус байдал байхгүй болно.

#### 6.4. Дүгнэлт

Дээр ХАОАТ-ын тогтоолцоон дахь 3 асуудал, хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлуудыг хөндөж ярилаа. Эдгээр асуудлыг яаралтай шийдвэрлэх урьдчилсан нөхцөл хараахан бүрдээгүй байна. ХАОАТ-ыг аваад үзэхэд орлогын түвшин бага, бүртгэл тооцоо хөтлөх дадал хэвшээгүй, татвар төлөгчдийн ухамсар сул байна. Үүний дээр татварын албанаас ХАОАТ-ын хяналт шалгалт явуулах хүн хүчний бололцоо муу байна. Татварын хяналт шалгалтыг голчлон ААНБ дээр явуулж, ХАОАТ-ын хяналт шалгалт суутгал, зарим нэг орлогыг нь тодорхойлоход хялбар хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчдийг хамрах төдийгээр хязгаарлагдаж байна. Ихэнх хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчдэд тогтоосон нэг хэмжээний татвар ногдуулж байна.

Эдгээр хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчдэд татварын үндсэн хувь хэмжээгээр татвар ногдуулбал ихэнхи татвар төлөгчид тайлан гаргаж өгөхгүй эсвэл цөөхөн хэсэг нь тайлангаа гаргах байх. Энэ байдлыг засахын тулд татварын албанд олон тооны татварын хяналт шалгалтын ажилтан хэрэгцээтэй болох бөгөөд ихэнх тохиолдолд жишгээр татвар ногдуулах зайлшгүй шаардлага гарч ирнэ.

Уг хуулинд жишгээр татвар ногдуулах тухай заалт байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэх тухай журам ч гарсан байгаа тул процедурын тал дээр асуудал гарахгүй боловч цаг, хүн хүч их шаардагдана.

Ямар ч байсан систем, бүтцээ боловсронгуй болгосон ч түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдээгүй бол энэ нь зөвхөн цаасан дээр үлдэхээс хэтрэхгүй.

Мэдээжийн хэрэг одоогийн байдлаар хэрэгжүүлэлтийг улам боловсронгуй болгосноор татвар ногдуулалтыг зөв зохистой адил тэгш болгох боломжтой юм. Үүний зэрэгцээ татвар төлөгчдийн мэдлэгийг дээшлүүлэх үүднээс сурталчилгаа, зөвлөгөө өгөх тогтолцоог боловсронгуй болгох, хяналт шалгалтын ажилтны ур чадварыг дээшлүүлэх, татвар төлөгчдөд зөвлөмж заавар өгөх ажиллагааг сайжруулах талаар татварын албанаас нилээн цаг гаргаж нухацтай ажиллах шаардлагатай байна.

---

Жич: Жишгээр татвар ногдуулах аргачлалыг III хэсгийн 2-р бүлэгт татварын хяналт шалгалтанд хэрэглэхэд дөхөмтэй болгохын тулд системчлэн цэгцэлж орууллаа.





**Бүлэг 7**



## **7. Аж ахуйн нэгж, байгууллагын болон хүн амын орлогын албан татварын хуулинд оруулах нийтлэг өөрчлөлтийн талаар**

### **7.1. Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлогод татвар ногдуулах тухай**

Одоо үйлчилж буй аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын болон хүн амын орлогын албан татварын хуулинд үл хөдлөх хөрөнгө шилжүүлсэн (борлуулсан) тохиолдолд борлуулалтын орлогын дүнд 2 хувиар татвар ногдуулах тухай заасан байдаг (аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэг, хүн амын орлогын албан татварын хуулийн 8 дугаар зүйлийн 3 дугаар заалт).

Уг заалтыг дор дурдсан шалтгааны үүднээс борлуулалтын орлогын дүнгээс худалдаж авсан өртөг болон борлуулалтын зардлыг хассан дүнд тус хуулиудад заасан хувь хэмжээгээр татвар ногдуулахаар өөрчлөх хэрэгтэй байна. Мөн үүний зэрэгцээ орон сууцны зориулалтын барилгыг бусдад эсвэл улс, орон нутагт шилжүүлсэн тохиолдолд 3 жилийн дотор нэг удаа дээд тал нь 10 сая төгрөгийн тусгай хөнгөлөлт үзүүлэхийг зөвшөөрөх гэх мэт нийгмийн асуудлыг бас харгалзан үзэх шаардлагатай.

- 1) Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого нь эзэмших хугацаанд үнэ өссөн хөрөнгийг бусдад шилжүүлэх үед гарах орлого бөгөөд хөдөлмөрийн бус замаар олох орлого тул татвар төлөх чадвар харьцангуй өндөр юм. Гэтэл энэхүү орлогод ногдуулах татварын хувь хэмжээ нь үл хөдлөх хөрөнгөнөөс орлого олоогүй аж ахуйн нэгж, байгууллага болон цалингаас өөр орлогогүй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ногдуулах татварын хувь хэмжээнээс үлэмж багаар тогтоогдсон байгаа нь татварын эрх тэгш зарчмын үүднээс тохиромжгүй заалт болох нь харагдана. Одоогийн татварын хувь хэмжээ болон татвар ногдуулах арга хэлбэрийг энэ хэвээр нь өөрчлөлгүй орхивол үл хөдлөх хөрөнгөгүй татвар төлөгчийн зүгээс нэлээд эсэргүүцэл гарах болно.

Иймээс одоогийн 2 гэсэн тусгай хувь хэмжээгээр бус, ядаж хүн амын орлогын албан татвар болон аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хувь хэмжээгээр татвар ногдуулах нь зүйтэй. Гэхдээ татвар ногдуулах орлогыг тооцохдоо борлуулалтын орлогын дүнгээс худалдан авалтын өртөг болон борлуулалтын зардлыг хасч тооцон, татвар төлөх чадварт зүй зохистойгоор зохицуулах хэрэгтэй.

- 2) Монгол улсад хойшид газар, барилга байшин гэх мэт үл хөдлөх хөрөнгийн хувьчлал улам идэвхжиж, үүнтэй уялдан үл хөдлөх хөрөнгийн арилжаа улам өргөжих нь тодорхой. Мөн эдийн засгийн хөгжилтэй уялдан газар гэх мэт үл хөдлөх хөрөнгөөс олох ашиг ч өсөх ба харин үүнд бага хэмжээний татвар ногдуулбал татварын эрх тэгш байдлыг яах аргагүй зөрчсөн хэрэг болно. Мөн газар гэх мэт үл хөдлөх хөрөнгөд ногдуулах татвар бага бол гадаадаас хөрөнгө

оруулалтын шинжтэй үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт газар авч, Монгол улсын үл хөдлөх хөрөнгийн эрүүл бодлогод саад бэрхшээл учирч мэдэх юм.

Дээр дурдсанчлан газар, барилга гэх мэт үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод бараа материал борлуулах болон хөрөнгө түрээслүүлэх зэргээс олох орлоготой адил татвар ногдуулах ёстой бөгөөд бага хувь хэмжээгээр тусад нь татвар ногдуулах учир шалтгаан үүнд байхгүй юм.

Борлуулалт явагдах үед нь борлуулалтын орлогын үнийн дүнгээс 5, эсхүл 20 орчим хувийн орлогын татвар суутган авч, жилийн татварын тайлан гаргах үеэр татварын тооцоог нэгтгэн гаргах аргыг нэвтрүүлэх явдлыг хянаж үзэх хэрэгтэй.

Өсч болох төсвийн орлогын дүн

Дараахь жишээн дээр төсвийн орлого хэрхэн нэмэгдэж болохыг тооцож үзье:

1999 оны аж ахуйн нэгж, байгууллагын болон иргэдийн үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод ногдох татвар 2%, худалдан авсан өртгийг борлуулалтын орлогын дүнгийн 50 хувьтай тэнцүү гэж үзээд үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод ногдох татвар (татварын хувь хэмжээ 40%)-ын хэмжээг тооцвол дор дурдсан үзүүлэлт гарч байна.

- ① 1999 оны үл хөдлөх хөрөнгийн татварын хэмжээ 218,015,000төг
- ② 1999 оны үл хөдлөх хөрөнгө борлуулсан нийт үнийн дүн = 1 / 2% = 10,900,750,000төг
- ③ 1999 оны үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын ашгийн хэмжээ = 2 \* 50% = 5,450,375,000төг
- ④ 1999 оны үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын ашигт тус тус татварын хувь хэмжээгээр ногдуулсан татвар = 3 \* 40% = 2,180,150,000төг
- ⑤ 1999 оны татвар өсөлтийн бодит хэмжээ = 4 - 2%-иар ногдуулсан татварын нийт хэмжээ (218,015,000) = 1,962,135,000төг

## Бүлэг 8



## **8. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн өөрчлөлттэй холбогдох санал**

### **8.1 НӨТ-ын өнөөгийн байдал**

Монгол улсад НӨТ-ыг хэрэгжүүлэх нийгэм эдийн засгийн нөхцөл байдал бүрэн гүйцэд төлөвшөөгүй байгаа гэсэн ч НӨТ-ын орлого 2000 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр (Статистикийн мэдээ 6 сар) татварын төрлүүд дотроос хамгийн их 26.6 тэрбум төг. болж татварын нийт орлого (нийгмийн даатгалын хураамжийг оролцуулаад)-ын 27%-ийг (төвлөрсөн төсвийн 30%) эзэлж байна. НӨТ ямар чухал байр суурь эзэлж байгаа нь энэ тооноос харахад ойлгомжтой бөгөөд энэ татварыг нийт 2054 (2000 оны 4 сарын байдлаар. Гэхдээ 30000 татвар төлөгч аж ахуйн нэгж бүртгүүлсэн байгаа бөгөөд хувь хүмүүсийн борлуулалтанд НӨТ ногдуулахгүй байгаа байдал үргэлжилсээр байна) дотоодын томоохон аж ахуйн нэгжүүд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд үүрч байгаа бөгөөд татварын байгууллага эдгээр аж ахуйн нэгжтэй байнгын харилцаатай ажилладаг.

Жич: Хэлтэс тасгуудын ажлын хуваарилалт дараах байдалтай байна.

#### Хяналт шалгалтын хэлтэс

2 ажилтан нэг групп болж НӨТ-ын буцаан олголтын хэмжээг тогтоож нэмэгдсэн өртгийн албан татварын хяналт шалгалтыг томоохон аж ахуйн нэгжид жил дараалан, бусад аж ахуйн нэгжид 2 жилд нэг удаа нягтлан бодох бүртгэл болон шаардалагтай бусад бичиг баримтыг шалгах замаар хийдэг ба шаардлагатай тохиолдолд тухайн татвар төлөгчийн харилцагч аж ахуйн нэгжид давхар шалгалт хийхэд 7 хоног орчим зарцуулдаг. Хяналт шалгалтын хэлтэс нь падааны үнэн зөв эсэх, буцаан олголтын лавлах шалгалтыг явуулдаг маш чухал үүрэгтэй хэлтэс юм.

#### Татвар ногдуулалтын хэлтэс

Тайланг шалгах болон тайлан гаргахтай холбогдсон зааварчлагаа өгөх ажил голлон эрхэлдэг. Татварын тайлантай хамт падаан зэрэг холбогдох нягтлан бодох бүртгэлийн бичиг баримт болон урьдчилсан тооцоог татавар төлөгчдаас гаргуулан авдаг ба аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох ажилтан нараас удирдлагын бодлогын талаар асууж лавлан үйлдвэрлэлийн байдалтай танилцахын зэрэгцээ 2-3 хоногийн хугацаанд шуурхай хяналт шалгалт хийх ба 3 жилд нэг удаа иж бүрэн шалгалт хийдэг (голлон санхүүгийн болон холбогдох бичиг баримтыг тулган шалгадаг ба шаардлагатай тохиолдолд тухайн татвар төлөгчийн харилцагч аж ахуйн нэгжид давхар хяналт шалгалт хийдэг)

#### Татварын хэлтэс

Татварын албанд харьяалагдах аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн хэлбэр энгийн байдаг тул үйлдвэрлэлийн бодит байдлыг ойлгоход хүндрэлтэй бус, зөвхөн нэмэгдсэн өртгийн албан татварын хяналт шалгалтын хүрээнд авч үзэхэд тайлан гаргах татвар төлөгчийн тоо цөөхөн байдаг тул онцгой хүндрэл гардаггүй.



## **8.2 Тулгамдсан асуудлууд ба түүнийг шийдвэрлэх арга зам**

### **8.2.1. Хэрэгжилтийн тал дээр тулгарах бэрхшээлтэй асуудлууд ба түүнийг шийдвэрлэх арга зам**

ҮТЕГ, Улаанбаатар хотын татварын газрын татвар ногдуулалт болон хяналт шалгалтын хэлтэс, дүүргийн татварын хэлтсийн нэмэгдсэн өртгийн албан татвар хариуцагч байцаагч нараас хуулийн хэрэгжилтийн талаар асууж сонслоо. Үүн дээр үндэслэн НӨТ-ийн хэрэгжилттэй холбоотой дараах хэдэн асуудлуудыг онцлон авч үзье гэж бодож байна.

- ① Татвар төлөгч падаан бичихдээ хойрго, бүртгэл хөтлөх явдал хэвшээгүй, НӨТ-ийн хэмжээг үнэн зөв тогтооход шаардлагатай нягтлан бодох бүртгэл хангалтгүй байна.
- ② Татвараас чөлөөлөх заалт өргөн хүрээг хамардагаас гадна тодорхой бус байгаагаас зохистой хэмжээнээс илүү чөлөөлөлт үзүүлж байна.
- ③ Хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгохын зэрэгцээ хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх явдал чухал.

Дээрх байдлаас харвал нэмэгдсэн өртгийн албан татвартай холбогдох гол асуудал нь татварын газарт харъяалагдах татвар төлөгчдийг тойрсон буцаан олголтын асуудал, зөрчил илрүүлэхэд чиглэсэн нарийн хяналт шалгалтыг ямар аргаар яаж үр дүнтэй явуулах вэ түүний тулд ямар арга хэмжээ авах вэ гэдэгт оршиж байна.

НӨТ төлөгчдийн хүрээг өргөтгөх нь гол зорилтын нэг болж байна. Одоогийнх шиг татвар төлөгчтэй ойр дөт ажиллах боломжгүй болох учраас хяналт шалгалтын системийг бэхжүүлэх боловсронгуй болгох асуудлыг орхигдуулж болохгүй. Хяналт шалгалтын ажлын удирдлага хяналтын тогтолцоо болон мэдээллийн системийг сайжруулж бусад байгууллагатай хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй.

Татварын бодлого болон татварын хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон заавар, журмыг нэлээд эмхэлж цэгцэлж буй боловч хэрэгжүүлэх ажил зохих журмын дагуу явагдахгүй байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Хууль журам болон VTEГ-ын тушаал шийдвэр төлөвлөсөн хэмжээнд хэрэгжиж байгаа эсэх талаар тавих хяналтын тогтолцоо болон хуулийн хэрэгжилтийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх нь чухал юм (дээд шатны байгууллага болон удирдах албан тушаалтны өгсөн үүрэг даалгаврыг ажилтнууд биелүүлж чадах нөхцлийг бүрдүүлж өгөх).

Дор даруй судалж үзэх шаардлагатай гол асуудлын талаар авч үзье.

### **8.2.2. Бусад бэрхшээлтэй асуудлууд ба түүнийг шийдвэрлэх арга зам**

- (1) Татварын суурийг харьцангуй явцуу хүрээнд тогтоосон талаар

Энд татвар төлөгчдийн хүрээг хязгаарлагдмал байдлаар тогтоож татвараас чөлөөлөгдөх ажил үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалтын орлогын босгыг эдийн засгийн цар хүрээтэй нь харьцуулахад өндөр тогтоосон явдал, татвараас чөлөөлөх тухай заалт хэтэрхий олон байгаа зэргийг дурьдаж болно. Үүнийг өөрчлөх шаардлагатай бөгөөд хэрэгжилтийн явцад ч татварт хамрагдах этгээдийн тухай заалт тодорхой бус хэвээрээ байх, татварт хамруулахгүй орхих зэрэг явдал байна. Татварт хамрагдах этгээдийг тодорхой заах, зайлшгүй шаардлагатайгаас бусад чөлөөлөлтийг болиулах шаардлагатай.

Юуны өмнө хувь хүнийг татварын объектын гадна үлдээх нь шударга, эрх тэгш байх зарчимд харшлах тул энэ асуудлыг судлах хэрэгтэй. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдээс татвар хураах тогтолцоо хэвээрээ байгаа өнөө үед нягтлан бодох бүртгэлийн шаардлагатай бичиг баримтыг хувиараа хөдөлмөр эрхлэгч бүрдүүлэхгүй бөгөөд ийм нөхцөл байдалд тэдгээрт нэмэгдсэн өртгийн албан татварын хяналт шалгалт хийх нь зардлын хувьд ч бэрхшээлтэй гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ урьдын адил хязгаарлагдмал аж ахуйн нэгжид л хяналт шалгалт хийвэл шударга бус татвар төлөгчдийг өөгшүүлнэ гэсэн үг. Хуулиар татвар төлөх үүрэгтэй хувь хүмүүсийг хуулийн гадна үлдээх нь татварын тухай ард түмний итгэлийг бэхжүүлэх үүднээс аваад үзсэн ч байж боломгүй асуудал юм. Наад захын хязгаарлагдмал хүрээнд ч гэсэн хувь хүнд татвар ногдуулах ажлыг алхам алхмаар хийж эхлэх хэрэгтэй. Мэдээжийн хэрэг хяналт шалгалтыг тодорхой хэсэг татвар төлөгчдийн хүрээнд хийх шаардлага байгаа боловч хувь хүмүүст НӨТ-ын хяналт шалгалт хийх аргачлалыг боловсруулах шаардлагатай.

Мөн татвараас чөлөөлөх тухай заалт олон байгаа нь татварын баазыг өргөтгөхөд саад болж байгаа тухай дээр өгүүлсэн бөгөөд одоогийн өөрчлөлтөөр энэ байдлыг арилгах талаар алхам хийнэ гэж итгэж байна. Татвараас чөлөөлөх заалтыг багасгах нь чухал бөгөөд үүнд шаардлагатай мэдээллийг татварын алба бодит жишээн дээр тулгуурлан цуглуулах хэрэгтэй. Энэ асуудлыг ингээд орхилоо гэж үзэхэд татвар төлөгчдөд татварын чөлөөлөлтийн талаар буруу зөрүү ойлголт төрүүлэхгүйн тулд татварын байгууллагууд хуулийн заалтыг тайлбарлах талаар нэгдсэн нэг ойлголттой байх ёстой. Алба, хэлтэс өөр өөрөөр тайлбарладаг эсвэл ажилтнуудын тайлбар зөрдөг гэсэн үнэлэлт татвар төлөгчдийн дунд гарах юм бол татварын байгууллагын санал бодлыг үл тоомсорлох байдал бий болох бөгөөд энэ сөрөг хандлагыг залруулахад хэцүү болно. Татвар төлөгчдийн татварын албанд итгэх итгэлийг бэхжүүлэхийн тулд тодорхой бөгөөд ил тод тайлбар гаргах ажлыг гүйцэтгэх хэрэгтэй.

## (2) Хяналт шалгалтын байцаагчдын ур чадварыг дээшлүүлэх талаар

Хяналт шалгалтын байцаагч нартай уулзаж байхад тэд ажилдаа сонирхолтой, хяналт шалгалтын талаар өндөр мэдлэгтэй, ажлаа сайн гүйцэтгэж байгаа нь харагдаж байлаа.

Мөн удирдах албан тушаалд байгаа хүмүүсийн хувьд практик туршлага багын улмаас хяналт шалгалтын аргын талаарх мэдлэг дутмаг боловч ерөнхийдөө ажиллах хүсэл эрмэлзэл, хариуцлага өндөртэй байдал ажиглагдсан. Гэхдээ байгууллагыг бүхэлд нь авч үзэхэд тушаал заавар журам гаргаад л орхичих бус бас түүний бодит байдал дээрх хэрэгжилтийг хянах хяналтын тийм систем үгүйлэгдэж байна. Заавар, журам гаргасан бол түүний хэрэгжилтэнд тавих дээд шатны байгууллага, удирдлагын хяналт чухал шаардлагатай. Энэ тал дээр анхаарах хэрэгтэй болов уу.

Татварын ажил дээр татварын хяналт шалгалтыг тухайн нөхцөл байдалд тохируулан явуулах явдал элбэг тохиолддог бөгөөд хяналт шалгалтыг голлон ямар чиглэлээр явуулахыг татварын байцаагчид бие даан шийдэхэд хүрэх явдал их байдаг. Гэхдээ дундаас доош албан тушаалтанд чиглэл заавар өгч, түүний дагуу хяналт шалгалт явагдсан эсэхийг тогтмол хянаж байх зайлшгүй шаардлагатай. Иймэрхүү байдлаар ажиллаж байгаа гэсэн тайлбар ирж мэдэх ч миний ажигласнаар бол татварын хяналт шалгалтын тайлан хэт товчхон, бодит нөхцөл байдлын талаарх зүйл бага орсон, дээд байгууллагын зүгээс тавих хяналт, цаашдын хяналт шалгалтад шаардлагатай баримт мэдээ дутмаг зэрэг байдал ажиглагдсан. Цааш цаашдын хяналт болон татварын хяналт шалгалтад шаардагдах бодит баримт материал бүхий хяналт шалгалтын дүгнэлт акт бичдэг тогтолцоог бий болгох талаар анхаарахыг энд дурдмаар байна.

Мөн татварын хяналт шалгалтын онцлогт анхаарал хандуулж туршлагатай ахмад ажилтанд шинэ залуу ажилтанг хариуцуулж хяналт шалгалтыг газар дээр нь удирдах (хяналт шалгалтын ажлын байран дахь сургалтыг явуулах) хэрэгтэй. Хяналт шалгалтын байцаагчдыг ерөнхий сургалтанд хамруулахын зэрэгцээ анги танхимд сургах боломжгүй хяналт шалгалтын арга технологийг практик дадлага туршлагаар заах, эзэмшүүлэх хэрэгтэй гэж үзэж байна. Ийм сургалтын арга барилд тулгуурлан системтэй сургалтын тогтолцоог нэвтрүүлэх талаар судлах хэрэгтэй.

### (3) Мэдээлэл хяналтын системийг боловсронгуй болгох

Аж ахуйн нэгжтэй холбогдолтой бүх төрлийн мэдээллийг тус тусынх нь хувийн хэрэгт төрөлжүүлэн хадгалж ажилтнууд хоорондоо хэрэгцээтэй мэдээллээ харилцан солилцож байна. Гэхдээ одоохондоо мэдээлэл цуглуулах байдал хангалтгүй, хэрэглэж байгаа мэдээллийн хэмжээ бага байна. Иймээс мэдээллийг бүрэн дүүрэн цуглуулдаг болгоход хуулинд заасан мэдээллийн системийн талаарх заалтыг өргөжүүлэх нь хамгийн үр дүнтэй бөгөөд үндсэн чухал арга хэмжээ юм. Жишээлбэл тайлантай хамт гаргаж өгсөн нэхэмжлэл, хяналт шалгалтын үеэр цуглуулсан нэхэмжлэл зэргийг хувиалан авч тухайн аж ахуйн нэгжийн хувийн хэрэгт хийх (гэхдээ аж ахуйн нэгжийн өөрийнх нь гаргаж өгсөн материал дотор байгаа тохиолдолд үр дүн бага байж ч магадгүй). Гэхдээ ийм зүйл дээр ч буруу зөрүү мэдээлсэн зүйлийг олж илрүүлж байсан жишээ байдаг. Хариуцсан татвар төлөгч аж ахуйн нэгждээ хяналт шалгалт хийхийн хамт нэхэмжлэл гаргагчдад ч тавих хяналтыг хүчтэй болгох замаар нэхэмжлэлийн утга учрыг өндөржүүлэх шаардлагатай. Хяналт шалгалтын үеэр олж авсан

мэдээ материалыг үр дүнтэй ашиглах явдлыг сайжруулж, тэдгээрийг ашиглах арга замыг хөгжүүлэх, мэдээллийн үнэ цэнийг зөв үнэлж сурах явдал чухал.

Жич: Мөн НӨТ-ын татвар төлөгчөөр бүртгүүлсэн эсэхийг нийтэд зарлаж, бүртгүүлээгүй этгээд нэхэмжлэл бичиж байгааг таслан зогсоох талаар арга хэмжээ авах талаар яригдаж байна. Гэхдээ татвартай холбоотой хувь хүний мэдээллийг ямар хэмжээнд нийтэд мэдээлж болох тухай бас бодож үзэх хэрэгтэй. Үүнийг тодорхой болгох юм бол нэхэмжлэлийн ач холбогдлыг өндөржүүлэхэд ямар нэг хэмжээгээр тус дөхөм болно.

#### (4) Жишиг татварыг хэрэгжүүлэх талаар

Нэмэгдсэн өртгийн албан татварын хяналт шалгалт, аж ахуйн нэгжийн албан татварын хяналт шалгалтанд ч гэсэн зардлын хяналт шалгалттай адилаар буцаан олголтын хувьд ямар нэгэн баримт материал байхад хяналт шалгалтын тулах цэгийг олох, түүнийг үргэлжлүүлэхэд хялбар байдаг. Гэвч борлуулалтын талаар тулгуур материал багатай бол хяналт шалгалт явуулахад бэрхшээлтэй. Энэ байдлыг арилгах нэг гол арга нь жишгээр татвар ногдуулах явдлыг хэрэгжүүлэх явдал юм. Гэвч жишгээр татвар ногдуулах тухайд татварын албаны туршлага нимгэн байгаа одоо үед шүүхийн байгууллагаас хөдөлшгүй итгэл үзүүлнэ гэж хэлэхэд хэцүү юм. Тиймээс ч жишгээр татвар ногдуулахыг хуулийн дагуу явагдсан байсан ч хориглон зогсоох явдал гардаг. Үнэн хэрэг дээрээ жишгээр татвар ногдуулах нь хуулиар зөвшөөрөгдсөн татвар ногдуулах арга бөгөөд хяналт шалгалтын хэлтсээс түүнийг хэрэгжүүлэх арга замын талаарх судалгааг үргэлжлүүлж хариуцсан ажилтнуудад нэгдмэл нэг ойлголт өгөх хэрэгтэй байна. Гэвч шүүхийн байгууллагын дээр өгүүлсэн байр сууринаас болж энэ нь арга нь практикт төдийлэн сайн нэвтэрч чадахгүй байгаа бөгөөд нэмэгдсэн өртгийн албан татвар ч төдийгүй бусад татварын хувьд ч нэг том бэрхшээл болж байна.

ҮТЕГ энэ аргыг татварын эрх тэгш зарчмыг хангахад зайлшгүй шаардлагатай арга гэж үзэн борлуулалтыг үнэн зөвөөр тодорхойлохын тулд зайлшгүй нэвтрүүлэх хэрэгтэй (Ялангуяа шүүхэд нэхэмжлэл гаргах асуудлыг ҮТЕГ хариуцсан тохиолдолд). Тиймээс бусад асуудлууд (хувь хүнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах)-аар ч гэсэн ҮТЕГ-ын удирдлагын дор туршилтын хяналт шалгалт явуулж хяналт шалгалтын аргачлал, бодлогыг боловсруулах шаардлагатай.

Мөн нэмэгдсэн өртгийн татварын хяналт шалгалтыг явуулахдаа борлуулалтын үнэн зөв эсэхтэй холбоотой асуудлуудыг онцлон авч үздэг бөгөөд Японд бол урьд төлсөн НӨТ-ын хасалтыг холбогдох баримт материал бүрдсэн нөхцөлд л хийдэг. Монголд ч гэсэн хуулиар үүнтэй адил арга хэмжээ авдаг гэж бодож байна. НӨТ-ын хяналт шалгалтын материал нь аж ахуйн нэгжийн татварын хяналт шалгалт явуулахад ч хэрэг болдог гэдгийг гүнзгий ухамсарлан аж ахуйн нэгжийн татварын нэгдсэн хяналт шалгалтыг гүйцэтгэх тогтолцоо бүрдүүлэх нь чухал юм.

(5) Бусад байгууллагатай хамтран ажиллах тогтолцооны талаар

Татварын үйл ажиллагаанд мэдээллийн олон эх үүсвэрийг ашиглан, баялаг мэдээллийн баазтай байх нь чухал юм. Жишээ нь одоо мөрдөж буй нэмэгдсэн өртгийн татвар ногдуулах үйл ажиллагаа гаалийн байгууллагын нэмэгдсэн өртгийн татвар ногдуулах үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Тиймээс энэ 2 байгууллагын нягт хамтын ажиллагаа чухал бөгөөд энэ тал дээр бүх зүйл шаардлагын түвшинд хэвийн явагдаж байгаа гэж хэлж боломгүй байна. Монголын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж байгаа ихэнх техник, тоног төхөөрөмжийг импортоор оруулж ирж байгаа бөгөөд энэ үйл ажиллагааг бүрэн дүүрэн хянаж байдаг газар нь гааль юм. Гаалийн байгууллагын материалыг олж авч ашигласнаар аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зохих хэмжээгээр мэдэж авч болно. Мэдээжийн хэрэг буцаан олголтонд үндсэн материал болгон үр дүнтэй ашиглах боломжтой гэж үзэж байгаа боловч, мэдээлэл солилцоогоор нэг үзэл санаан дээр тулгуурласан үйл ажиллагаа явуулах үндсийг бүрдүүлснээр хоёр талын НӨТ-ийн нэгдмэл үйл ажиллагааны биелэлтийг хангаж чадна. Өөр бусад шаардлагатай байгууллагатай хамтран ажиллах шаардалагатай байгууллага байвил хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар идэвхтэй ажиллах хэрэгтэй.

Мөн НӨТ-ын тухай мэдээлэл бүхий холбогдох улсын байгууллагатай хамтран хяналт шалгалт явуулахаас гадна хувийн хэвшлийн байгууллагын хүчин туслалцааг ч авах нь бас чухал юм. Жишээлбэл санхүүгийн бүртгэл хөтлөж занших болон НӨТ төлөгчийн бүртгэлийн ажлыг сайжруулах үндсэн орчин нөхцлийг бүрдүүлэх асуудлыг цаашид шийдэх хэрэгтэй бөгөөд үүнийн тулд чадавхи боломж сайтай харилцагч аж ахуйн нэгжийнх нь зүгээс ТМНБ-ын зөвлөмжөөр дамжуулан нөлөөлөх нь татварын алба шууд оролцон явуулахаас илүү үр дүнтэй бус уу. Аж ахуйн нэгжид зайлшгүй шаардлагатай хэмээн мэдрэгдэхгүй байгаа зүйлийн тухайд аж ахуйн нэгжийн ашиг сонирхол, байр сууринаас авч үзэж хувийн хэвшлийн байгууллагаар дамжуулан явуулах аргыг хайх нь зүйтэй юм.

## Бүлэг 9



## **9. Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуульд оруулах өөрчлөлттэй холбогдох санал**

Үл хөдлөх хөрөнгийн албан татвар нь биет хөрөнгө эзэмшиж буй аливаа этгээдэд ногдуулах татвар бөгөөд бусад татварын төрөлтэй харьцуулахад тооцоолоход харьцангуй хялбар байдгаас татварын хувь хэмжээг багаар тогтоох тохиолдолд татвар төлөгчийн зүгээс эсэргүүцэл бага гарах маш үр ашигтай орлогын тогтолцоо учраас судалгааны хэсгээс түүнийг нэвтрүүлэх талаар зөвлөмж болгосны дагуу одоо хэрэгжиж байна.

Батлагдсан хуулинд судалгааны хэсгийн санал тусгагдсан зүйл байгаа бөгөөд өөрчлөх шаардлагатай чухал гэж үзсэн зүйлийн талаар энд зөвлөмж болгое.

### **9.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт өөрчлөлт оруулах тухай**

Хуулийн 3-р зүйлийн 1-ийг дараах маягаар өөрчлөх хэрэгтэй.

#### **Хууль**

Монгол улсын Иргэний хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлогдсон бүх төрлийн үл хөдлөх эд хөрөнгөнд албан татвар ногдуулна.

#### **Өөрчлөлт**

Үл хөдлөх хөрөнгө бүртгэгдсэн эсэхээс үл хамааран бүх эзэмшигчдийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгөд албан татвар ногдуулна. Мөн эзэмшигчийн өөрөө барьж байгуулсан аливаа үл хөдлөх хөрөнгөнд нэгэн адил татвар ногдуулна.

#### **Тайлбар**

Уг заалт нь татвар ногдуулах үл хөдлөх хөрөнгийн тухай заасан заалт юм. Татвар ногдуулах үл хөдлөх хөрөнгийг үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн эсэхээр хязгаарлах шаардлагагүй тул аливаа этгээдийн эзэмшилд буй бүх төрлийн үл хөдлөх хөрөнгийг татвар ногдуулах эд хөрөнгө гэж үзэх тухай тодруулсан заалт юм. Түүнчлэн эзэмшигч өөрөө барьж байгуулсан үл хөдлөх хөрөнгийг мөн адил татвар ногдох хөрөнгө гэж тооцох тухай заалтыг тодотгосон зүйл юм.

### **9.2 Хуулийн 4 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт өөрчлөлт оруулах тухай**

Хуулийн 4-р зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан нэмэлт өөрчлөлтийг оруулах хэрэгтэй.

#### **Өөрчлөлт**



Жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний үдээс өмнөх 0 цагийн байдлаар Монгол улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх хөрөнгө эзэмшиж буй дор дурдсан этгээд үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөх үүрэг хүлээнэ.

Тайлбар

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуулийн 4 дүгээр зүйл нь үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөх үүрэгтэй этгээдийг зааж өгөх бөгөөд уг хэсгийг оруулснаар «жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрийн үдээс өмнөх 0 цагийн байдлаар үл хөдлөх хөрөнгө эзэмшиж буй этгээд»-ийг тусгайлан зааж тодотгож өгсөн болно.

### **9.3 Хуулийн 5 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт өөрчлөлт оруулах тухай**

Хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг дор дурдсан байдлаар өөрчлөх хэрэгтэй.

Хууль

Үл хөдлөх хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уг хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тодорхойлно.

Өөрчлөлт

Үл хөдлөх хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг татварын албанаас тогтоосон аргачлалын дагуу тодорхойлно.

Тайлбар

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуульд заасан татварын үнэлгээг тогтоох тухай энэхүү заалт нь үл хөдлөх хөрөнгийн бүртгэл хийгдээгүй хөрөнгөнд хамаарахгүй бөгөөд одоогийн Монгол улсын үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газраас тогтоосон үнэлгээ нь бүртгэл хийх үеийн үнэлгээ тул зөвхөн энэ үнэлгээнд тулгуурлаж үл хөдлөх хөрөнгийн албан татварын хэмжээг үнэн зөв тогтоох боломжгүй. Хэдийгээр уг үнэлгээг үл хөдлөх хөрөнгөнд ногдох татварын хэмжээг тогтоох нэг хэмжүүр гэж үзэж болох хэдий ч үнэн зөв татвар ногдуулах бүрэн үндэслэл болж чадахгүй.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын үнэлгээг үл хөдлөх хөрөнгийн татварын зорилгод нийцүүлэн үнэн зөв үнэлгээ хийх шаардлагатай тул татварын алба өөрсдөө үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийдэг болох шаардлагатай.

Иймээс энэхүү өөрчлөлт нь үл хөдлөх хөрөнгийн албан татварын зорилгод нийцүүлэн татварын байгууллагаас тогтоосон татварын үнэлгээ тогтоох арга болон бүртгэл хийгдээгүй үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ зэрэгт тулгуурлан жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар татварын үнэлгээ хийх тухай тодорхой зааж өгөх юм.

#### **9.4. Хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт өөрчлөлт оруулах тухай**

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуулийн 8 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийг дор дурдсаны дагуу өөрчлөх хэрэгтэй.

##### **Хууль**

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар байгаа үл хөдлөх хөрөнгийн үнэлгээгээр тооцно.

##### **Өөрчлөлт**

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар байгаа үл хөдлөх хөрөнгийн үнэлгээгээр тооцно.

##### **Тайлбар**

Жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрийн үдээс өмнө 0 цагийн байдлаар татвар төлөгчийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгөнд татвар ногдуулна гэсэн хуулийн 4 дүгээр зүйлийг өөрчлөх шаардлагатай ба уг заалтанд тулгуурлан үл хөдлөх хөрөнгийн татварын үнэлгээ хийх хугацааг нэгэн адил 1 дүгээр сарын 1-ний байдлаар гэж өөрчилж оруулав. Хэрэв 1 сарын 15-ний өдрийн байдлаар татварын тооцоо хийнэ гэж тогтоовол уг 4 дүгээр заалтанд заасан хугацааг ч мөн адил 1 сарын 15-ны өдрийн үдээс өмнөх 0 цагийн байдлаар гэж өөрчлөх шаардлагатай. Гэхдээ 1 дүгээр сарын 15-ны өдөр гэж сарын дунд хугацаагаар зааснаас илүүтэйгээр оны эхний хоногоор татварын тооцоо хийхээр өөрчлөлт хийвэл татвар төлөгчийн хувьд ч гэсэн ямар нэгэн маргаан будлиан бага гарна гэж үзэж байна.

#### **9.5 Хуулийн 8 дугаар зүйлийн 2, 3 дугаар хэсэгт өөрчлөлт оруулах тухай**

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгүүдийг дор дурдсаны дагуу өөрчлөх шаардлагатай.

##### **Хуулийн 8-р зүйлийн 2**

Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч хуулийн этгээд нь үл хөдлөх хөрөнгийн жилийн албан татварыг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор тэнцүү хэмжээгээр бодож тооцож төлнө

##### **Хуулийн 8-р зүйлийн 3**

Үл хөдлөх эд хөрөнгийг эзэмшигч монгол улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн үл хөдлөх хөрөнгийн албан татварыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор нэг удаа төлнө.

##### **Өөрчлөлт**

2-р хэсэг

Үл хөдлөх хөрөнгө өмчлөгч монгол улсын иргэн, хуулийн этгээд нь үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор төлнө.

### 3-р хэсэг

Үл хөдлөх эд хөрөнгө эзэмшигч гадаадын иргэн, хуулийн этгээд (бүх төрлийн байгууллагыг үүнд хамруулна), харъяалалгүй этгээд үл хөдлөх хөрөнгийн албан татварыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор нэг удаа төлнө.

### Тайлбар

Хуулийн 2 дугаар хэсэгт заасанчлан Монгол улсын иргэн, хуулийн этгээдийг тусад нь авч үзэх шаардлагагүй тул адилхан авч үзэх талаар тодруулж өөрчлөлт оруулсан бөгөөд 3-р хэсэгт гадаадын иргэн, хуулийн этгээд, харъяалалгүй этгээдэд татвар бүрэн ногдуулж, хурааж авч чадахгүй байгааг харгалзан тайлан гаргасных нь дараа нэг удаа татвар төлөх тухай тодотгон заасан юм.

## Бүлэг 10



## **10. Өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын тухай хуулийн өөрчлөлттэй холбогдох санал**

Өв залгамжлалын албан татвар нь эд хөрөнгийг өв залгамжлан авагчид ногдуулж буй татвар бөгөөд уг этгээдийн татвар төлөх чадвар өндөр, мөн хөрөнгө баялагийн хуваарилалтанд нэмэр хандив болж байгаа гэдэг утгаар авч үзвэл нэлээд өндөр хэмжээний хасалтыг хийсэн дүнгээс татвар авах тохиолдолд ердийн татвар төлөгчдийн зүгээс нэг их эсэргүүцэлгүйгээр хүлээн авах боломжтой татварын тогтолцоо юм. Бэлэглэлийн албан татвар нь эд хөрөнгийг бэлэг болгон авагчид ногдуулах татвар бөгөөд өв залгамжлалын албан татварыг нөхөх үүрэг гүйцэтгэх бөгөөд судалгааны хэсэг Монголд санхүүгийн бүлэглэлүүд үүсч бий болж байгаа өнөөгийн нөхцөл байдлаас үүдэн эдгээр татварыг яаралтай нэвтрүүлэх хэрэгтэй гэсэн санал зөвлөгөө өгч байсан.

Доор өв залгамжлал, бэлэглэлийн татварын хуулийн төсөл болон чухал гэж үзсэн зарим нэг хэсгийн тайлбарыг санал болгож байна.

### **Өв залгамжлал болон бэлэглэлийн татварын хуулийн төсөл**

#### **1-р зүйл            Хуулийн зорилго**

Уг хуулийн зорилго нь өв залгамжлал, бэлэглэлээр өмч хөрөнгө хүлээн авсан этгээдтэй холбоотой өв залгамжлалын болон бэлэглэлийн татвар, түүнийг төсөвт төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

#### **2-р зүйл            Өв залгамжлал болон бэлэглэлийн татвартай холбоотой хууль тогтоомж**

Өв залгамжлал болон бэлэглэлийн татвартай холбоотой хууль тогтоомж нь татварын ерөнхий хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

#### **3-р зүйл            Тодорхойлолт**

- 3.1 «Өв залгамжлал» гэдэг нь уг этгээд өөрийн өмч болон өмчлөх эрхийг холбогдох хууль тогтоомж, гэрээслэлийн дагуу гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хэлнэ.
- 3.2 «Бэлэглэл» гэдэг нь уг этгээд өөрийн өмч болон өмчлөх эрхийг гуравдагч этгээдэд үнэгүйгээр, эсвэл буцалтгүйгээр шилжүүлэхийг хэлнэ.

#### **4-р зүйл            Өв залгамжлалын болон бэлэглэлийн татвар төлөх үүрэг хүлээгч**

- 4.1. Дараах этгээдүүд уг хуулинд заасан өв залгамжлалын татвар төлөх үүрэг хүлээнэ.

4.1.1. Өв залгамжлалаар өмчийг өвлөн авагч Монгол улсад байнга оршин суугч этгээд, харьяалалгүй этгээд, аж ахуйн нэгж байгууллага

4.1.2. Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа өмчийг өв залгамжлал болон бэлэглэлээр хүлээн авсан Монгол улсад байнга бус оршин суугч

*5-р зүйл Өв залгамжлал болон бэлэглэлийн өмчийн үнэлгээ*

5.1 Өв залгамжлал болон бэлэглэлээр өмч хүлээн авсан тохиолдолд тухайн үеийн ханшийг үндэслэн өмчийг үнэлнэ.

*6-р зүйл Татвар ногдуулах үнэ*

6.1 Өв залгамжлалаар өмч өвлөн авсан этгээд нь хууль ёсны эхнэр, нөхөр байх тохиолдолд өвлөн авсан өмчийн үнийн дүнгээс 20 сая төгрөгийг хассан дүнд татвар ногдуулна.

6.2 Өв залгамжлалаар өмч өвлөн авсан этгээд нь төрсөн хүүхэд, төрсөн эцэг эх байх тохиолдолд өвлөн авсан өмчийн үнийн дүнгээс 10 сая төгрөгийг хассан дүнд татвар ногдуулна.

6.3 Эд хөрөнгө бэлэг болгон авагчид ногдох татварыг жилийн үндсэн хөнгөлөлтийн хэмжээ 500 мянган төгрөгийг хассан үнийн дүнд татвар ногдуулна.

**Тайлбар**

6-р зүйлд өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар ногдох хэмжээг тогтоосон бөгөөд эд хөрөнгө өвлөн авагч этгээд нь хууль ёсны эхнэр, нөхөр, төрсөн хүүхэд байх гэх мэтийн тохиолдолд тусгайлан тогтоосон хэмжээгээр хасалт хийсэн үнийн дүнгээр татварын хэмжээг тооцох, бусдаас эд хөрөнгө бэлэг болгон авагчийн хувьд 500 мянган төгрөгийг хассан үнийн дүнгээр тооцоолохоор тодорхойлж заасан юм.

Өв залгамжлуулагчийн үлдээсэн эд хөрөнгийг бүрдүүлэхэд оруулсан хувь нэмрийг харгалзан үзэж, хууль ёсны эхнэр нөхөрт ногдох татварыг бусад өв залгамжлагчийнхаас их хувь хэмжээгээр хөнгөлөх нь зүйтэй. Бэлэглэлийн албан татвар нь мөн чанартаа өв залгамжлалын албан татварыг нөхөх үүрэг бүхий татвар юм. Өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын тусгай хөнгөлөлтийн болон татварын хувь хэмжээ нь ижил, эсвэл бэлэглэлийн албан татварын хасалт өндөр хэмжээтэй байх нь өв залгамжлагч амьд үедээ бэлэглэсэн бэлэглэл гэсэн нэрийдлээр их хэмжээний хөрөнгийг багасгах замаар өв залгамжлалын албан татвараас зугатаах хууль бус үйлдлийг өөгшүүлэхэд хүргэх тул өв залгамжлалын албан татварын хуулиар эд хөрөнгийн төвлөрлийг арилгах үндсэн зорилго алдагдах боломж байгааг үгүйсгэх аргагүй юм. Иймд бэлэглэлийн албан татварын хөнгөлөлтийн хувь хэмжээ нь бага байхаар тогтоох хэрэгтэй гэсэн зарчмын дагуу өөрчлөлт хийх шаардлагатай.

*7-р зүйл Татварын хувь хэмжээ*

7.1. Өв залгамжлалын албан татварыг татвар ногдуулах үнэд үндэслэн дараах хэмжээгээр тогтооно.

Татвар ногдуулах үнэ (Төг)	Татварын хувь хэмжээ
10,000,001-20,000,000	10%
20,000,001-40,000,000	1 сая төгрөг дээр 20 сая төгрөгөөс давсан орлогын 20%-ийг нэмнэ
40,000,001-60,000,000	5 сая төгрөг дээр 40 сая төгрөгөөс давсан орлогын 30%-ийг нэмнэ
60,000,001-80,000,000	11 сая төгрөг дээр 60 сая төгрөгөөс давсан орлогын 40%-ийг нэмнэ
80,000,001-ээс дээш	19 сая төгрөг дээр 80 сая төгрөгөөс давсан орлогын 50%-ийг нэмнэ

7.2. Бэлэглэлийн албан татварыг татвар ногдуулах үнэд үндэслэн дараах хэмжээгээр тогтооно.

Татвар ногдуулах үнэ (Төг)	Татварын хувь хэмжээ (Төг)
500,001-5,000,000	10%
5,000,001-10,000,000	500,000 төгрөг дээр 5 сая төгрөгөөс давсан орлогын 20%-ийг нэмнэ.
10,000,001-20,000,000	2,500,000 төгрөг дээр 10 сая төгрөгөөс давсан орлогын 30%-ийг нэмнэ.
20,000,001-50,000,000	8,500,000 төгрөг дээр 20 сая төгрөгөөс давсан орлогын 40%-ийг нэмнэ.
50,000,001-аас дээш	16,500,000 төгрөг дээр 80 сая төгрөгөөс давсан орлогын 50%-ийг нэмнэ.

### Тайлбар

Өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын зорилго өөр учраас бэлэглэлийн албан татварын хэмжээг өв залгамжлалын албан татварын хэмжээнээс өндөр тогтоох нь мэдээжийн зүйл юм. Мөн одоогийн татварын албанаас явуулдаг татварын хяналт шалгалтанд бэлэглэлийн албан татварын тогтолцоо хамрагддаггүйгээс татвар төлөгч борлуулсан орлогоо бэлэглэл хэмээн татвараас зайлсхийх үзэгдэл гарч болох талтай бөгөөд бэлэглэлийн албан татварын хувь хэмжээг өндөр болгох нь зохистой юм.

### 8-р зүйл Татвар ногдуулахгүй өмч

8.1 Дараах өмчид өв залгамжлалын болон бэлэглэлийн албан татвар ногдуулахгүй.

8.1.1 Засгийн газар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өв залгамжлал, бэлэглэлээр хүлээн авсан өмч

8.1.2 Нийгмийн үйлчилгээ үзүүлдэг засгийн газрын бус байгууллагад өвлүүлсэн болон бэлэглэсэн өмч



*9-р зүйл Татвар төлөх, татварын тайлан*

- 9.1 Өв залгамжлал хүлээн авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор өв залгамжлалын татварын тайлан гарган татвараа төлнө.
- 9.2 Бэлэглэл хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор бэлэглэлийн татварын тайлан гаргаж татвараа төлнө.

**Тайлбар**

Их хэмжээний эд хөрөнгө өв залгамжилж буй тохиолдолд түүнийг олж тогтоох, үнэлэх ажилд нэлээд цаг хугацаа шаардлагатай тул бэлэглэлийн албан татварын тайлан гаргах, төлөх хугацаатай адил 30 хоног байх нь боломжгүй гэж үзэж «90 хоногийн дотор» гэж өөрчлөв.

- 9.3 10 сая төгрөгөөс дээш татвар төлөх этгээд нь тайлангаа гаргаснаас хойш харъяа татварын албатай ярьж тохирсны үндсэн дээр 1 жилийн дотор өв залгамжлалын болон бэлэглэлийн албан татвараа төлж болно.
- 9.4 Өв залгамжлалын эд хөрөнгөд хамаарах үл хөдлөх хөрөнгийг бэлэн мөнгөөр тооцоход бэрхшээлтэй тохиолдолд татвар ногдох үнийн дүнгээр эд хөрөнгөөр төлж болно. Хуульд заасан өв залгамжлалын албан татварын тайлан гаргах хугацааны дотор эд хөрөнгөөр төлөх өргөдөл гаргаагүй болон тухайн эд хөрөнгийг татварын алба хүлээн авах боломжгүй гэж үзсэн тохиолдолд энэ заалт үйлчлэхгүй.

**Тайлбар**

Их хэмжээний эд хөрөнгө өв залгамжлан авсан тохиолдолд бэлэн мөнгөөр төлөхөд бэрхшээлтэй асуудал гарч ирэх магадлалтай тул эд хөрөнгөөр татвар төлөхийг хүлээн зөвшөөрсөн заалт оруулав. Эд хөрөнгөөр татвар төлөх өргөдлөө хуульд заасан хугацааны дотор гаргах шаардлагатай бөгөөд татварын алба эд хөрөнгөөр төлөх боломжгүй гэж үзсэн тохиолдолд хүлээн зөвшөөрөхгүй байж болохыг тодруулав.

- 9.5. Өв залгамжлалын болон бэлэглэлийн албан татварын тайлангийн маягтыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална.

*10-р зүйл Хууль хүчин төгөлдөр болох тухай*

Энэ хуулийг 200..... оны ... сарын өдрөөс дагаж мөрдөнө.

### **III ХЭСЭГ**

**ТАТВАР ХУРААЛТЫН СИСТЕМД ТУЛГАРЧ БУЙ  
БЭРХШЭЭЛТЭЙ АСУУДАЛ БОЛОН ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

## Бүлэг 1

## 1. Албан ёсны квитанцын систем нэвтрүүлэх тухай

### 1.1 Зорилго, ач холбогдол, тайлбар

Аливаа татварын албаны эрхэм зорилго бол татварыг шударга, тэгш ногдуулах болон хураах, татварын хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх, татварын тогтолцоог бэхжүүлэхэд оршдог.

Монгол улсын хувьд татварын шинэ тогтолцоо бүрдээд удаагүй тул тогтолцоог боловсронгуй болгох, татвар төлөгчийн суурийг өргөжүүлэх, татвар ногдуулах болон хураах арга зүйг оновчтой, үр ашигтай болгох нь нэн тэргүүний зорилт юм.

Ялангуяа Монгол улсын эдийн засгийн байдал хүнд байгаа энэ үед дээрх чиглэлээрх асуудлыг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардагатай байна. Монгол орны эдийн засгийн нэг хүндрэлтэй тал бол далд эдийн засаг оршин буй явдал бөгөөд татварын орлогыг бүрдүүлэгч байгууллага болох татварын алба нь энэхүү далд эдийн засгийн сектороос огт татвар авч чаддаггүй, тэднээс татвар хураах ноу хау байхгүй байгаа билээ. Энэ нь Монгол улсын татвар хураалтын тэгш шударга зарчмыг ихээхэн зөрчихийн зэрэгцээ төрийн санхүүгийн зүй зохистой удирдлагад ноцтой бэрхшээл учруулж байна. Иймээс далд эдийн засгаас ямар арга замаар татварыг зүй зохистой, үр ашигтай байдлаар авах талаар манай судалгааны хэсэг тал бүрээр судлан үзэж, төслийн эхний шатанд «Албан ёсны квитанцын систем»-ийг болгох тухай санал гаргасан билээ.

ҮТЕГ 2000 онд хийсэн татварын системийн шинэчлэлтийн төсөлдөө «Албан ёсны квитанцын систем»-ийг авч үзсэн хэдий ч үүнийг нэвтрүүлэлгүй, харин Сангийн сайд, ҮТЕГ-ын даргын хамтарсан тушаалаар «Кассын машины систем» нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн билээ.

Гэвч энэхүү «Кассын машины систем» нь дараах сөрөг талтай болно.

[1] Монгол улсын Засгийн газрын хэргэжүүлэхээр төлөвлөөд байгаа одоогийн «Кассын машины систем»-ийг агуулгынх нь хувьд авч үзвэл, кассын машиныг татвар төлөгчдөөр худалдан авахуулаад түүнээс олсон орлогыг татвараас нь хасч өгье гэсэн санаа агуулж байгаа бөгөөд үнэн хэрэгтээ бол татвар төлөгчдөөр кассын машин авахуулна гэдэг нь тун боломж муутай зүйл юм. Кассын машин хамгийн хямддаа гэхэд л 700\$-оос буухгүй тул татвар төлөгч татвараар өөрийгөө дарамтлах тийм алхам тэр бүр хийхгүй нь ойлгомжтой.

Мөн татварын хасалтаар энэхүү асуудлыг шийдчихнэ гэх Монгол улсын засгийн газрын байр суурийн хувьд авч үзлээ ч кассын машин эхэлж худалдан авах нь татвар төлөгч бөгөөд урьдчилан энэ мөнгийг татвар төлөгчдөөр гаргуулна гэдэг нь Монгол улсын өнөөгийн нөхцөл байдалд үнэндээ тохирохгүй гэж хэлж болно. Татварын хасалт хийх тохиолдолд Монгол улсын төсвийн орлого тэр хэмжээгээр буурах нь ойлгомжтой бөгөөд үүнд угхүү систем нэвтрүүлснээр төсвийн орлого нэмэгдэнэ

гэсэн баталгаа алга байна. Зөвхөн том татвар төлөгчдөд л «Кассын машины систем» нэвтрүүлнэ гэдэг нь далд эдийн засагтай тэмцэхэд ямар ч хувь нэмэр болохгүй бөгөөд алсдаа зах гэх мэт газар үйл ажиллагаа явуулах хувиараа бизнес эрхлэгчид тэргүүтэй жирийн татвар төлөгч иргэдэд ямар арга замаар «кассын машины систем»-ийг нэг мөр нэвтрүүлэх талаарх бодлого Монгол улсын төрд алга байна. Зөвхөн цөөн хэдэн татвар төлөгчдөд энэхүү системийг нэвтрүүлэх нь төсвийн орлогын талаас авч үзлээ ч гэсэн нэг их ач холбогдолтой зүйл биш гэж хэлж болно.

- [2] «Кассын машины систем»-ийг түр хугацаанд нэвтрүүлсэн тохиолдолд ч татвараас зайлсхийх гэсэн татвар төлөгч бараа борлуулж, үйлчилгээ явуулаад кассын машинаа зарим үед хэрэглэлгүй, мөнгөө өөр газар хийж хадгалах замаар татвараас зайлсхийх боломжтой. Иймээс кассын машины систем нь татвараас зайлсхийгчдийг хамгаалах нэг арга зам болж байна гэж бид үзэж байна.  
Мөн далд хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчдөд энэ системийг нэвтрүүллээ ч татвараас зайлсхийх ямар нэг арга хэлбэр гарч ирэх нь ойлгомжтой бөгөөд «кассын машины систем» нь далд эдийн засгаас татвар авахад нэг их үр дүнгээ өгөхгүй болов уу.
- [3] Кассын машины бүртгэлд ерөнхийдөө харилцагчийн нэр гэх мэт холбогдох мэдээлэл тэмдэглэгддэггүй бөгөөд тухайн татвар төлөгчийн хяналт шалгалтанд түүний ач холбогдол их боловч түүгээр аль нэг татвар төлөгчийн бүртгэл, харилцагчийн бүртгэл хоёрыг харьцуулах замаар хяналт шалгалтыг үр ашигтай хийх боломжгүй тул татвар төлөгчийн тайлангийн үнэн зөвийг тогтооход зөвхөн кассын бүртгэлийг ашиглах нь үр дүн муутай болох бөгөөд үүнийг хяналт шалгалтын аргын туслах төвшингийн аргад тооцож явах нь зүйтэй юм.
- [4] Монгол улсын өнөөгийн нөхцөл байдлаас авч үзвэл, аж ахуйн нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааны шаардлагын улмаас кассын машиныг худалдан авах нь зайлшгүй бөгөөд цаашдаа ч худалдан авцгаах нь ойлгомжтой тул энэхүү системийг өнөөгийн нөхцөлд нэвтрүүлэх шаардлагагүй гэж үзэж байна.

Дээр дурдсанчлан «Кассын машины систем»-д олон бэрхшээлтэй асуудлууд байгаа хэдий ч ерөнхийдөө татвар төлөгчид кассын машинтай болох нь татварын албанд тун ашигтай юм. Гэхдээ өнөөгийн Монгол орны нөхцөлд далд эдийн засгаас татвар хураалтыг оновчтой, үр ашигтай зохион байгуулж, төсвийн орлогын өсөлтийг хангах асуудлыг шийдвэрлэхэд «Кассын машины систем» тохирохгүй бөгөөд харин Монгол улсын засгийн газар Монгол орны эдийн засгийн нөхцөл байдалд тохируулан эдгээр асуудлыг хялбар шийдье гэвэл «Албан ёсны квитанцын систем»-ийг хугацаа алдалгүй нэвтрүүлж, түүний хэрэгжилтийн ажилд орох нь чухал байна.

## 1.2 Албан ёсны квитанцийн системийн агуулга

### 1.2.1 Албан ёсны квитанцийн системийн агуулга

Тодорхой хэмжээний мөнгөн дүнгээс дээш хэмжээний дотоод дахь ажил гүйлгээ болон гадаадаас авсан бараа, үйлчилгээнд квитанц хэрэглэснээр үндэсний татварын албаны төв байгууллага бүхий л арилжааны талаарх мэдээллийг цуглуулах боломжтой болох бөгөөд энэ нь далд эдийн засгийг үр ашигтайгаар, бага өртөгтэйгээр илрүүлэх боломжтой хамгийн тохиромжтой арга юм.

Квитанцийн систем нь татвар төлөгчдийг бараа борлуулах, ажил үйлчилгээ үзүүлэх болгонд нь квитанци бичүүлж, татвар төлөгчийн борлуулалт болон худалдан авалтын дүнг тогтоох, татварын тооцоог зөв хийлгэх, татвар төлөгчдийг ашиг, зардал гэх мэт нотлох баримтанд тулгуурлан ажил гүйлгээний анхан шатны бүртгэл хөтөлж хэвшүүлэх зорилготой юм. Квитанцийн системийг Монгол улсад нэвтрүүлснээр татвар төлөгчдөд хийх хяналт шалгалтын үр ашиг дээшилж, татварын хэмжээг зөв тогтоох боломж үлэмж нэмэгдэх бөгөөд далд эдийн засаг, татвараас зайлсхийх явдлыг хязгаарлахын хамт эцсийн дүндээ Монгол улсын бодит эдийн засагт тохирсон төсвийн орлогыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой зүйл юм.

Квитанцийн систем нь дотоод арилжааны квитанц болон гадаад арилжааны квитанц гэж байна. Дотоод арилжааны квитанц нь Монгол улс дотор хийгдэж байгаа бүх арилжаанд хэрэглэгдэх бөгөөд татвар төлөгчийн дотоод дахь бизнесийн бүхий л үйл ажиллагааг татварын байгууллага квитанцийн мэдээллээр бага өртгөөр, хялбар аргаар мэдэх боломжтой. Гадаад квитанц нь гадаад, дотоодын татвар төлөгч гэдгээс үл хамааран Монгол улсын татварын хууль тогтоомжоор заагдсан татвар төлөгч хэн болвч ① гадаадаас бараа худалдан авч, ажил үйлчилгээ хүлээн аваад төлбөр хийсэн тохиолдол ② гадаадад бараа материал борлуулаад төлбөр авсан тохиолдолд тус тус хэрэглэгдэнэ. Татвар төлөгчийн гадаадаас хийсэн худалдан авалт болон гадаадад хийсэн борлуулалт гэх мэт бизнесийн бүхий л үйл ажиллагааг татварын алба квитанцийн мэдээллээс бага өртгөөр буюу хялбар аргаар олж илрүүлэх боломжтой.

Квитанцийн системийн талаар товч танилцуулъя.

[1] Дотоод арилжааны квитанци

- 1) Дотоод арилжааны квитанц (цаашид «дотоод квитанц» гэх) - ийг үндэсний татварын албаны төв байгууллагаас татвар төлөгчдөд үнэ төлбөргүйгээр тараах ба тухайн жилдээ хүчинтэй байх бөгөөд дотоод дахь бүх төрлийн арилжаанд хэрэглэнэ.
- 2) Дотоодын квитанцийг 3 хувь үйлдэх бөгөөд нэгдэх хувь нь үндэсний татварын албаны төв байгууллагад, хоёрдахь хувь нь харилцагч талд, гуравдахь хувь нь татвар төлөгч өөрт нь үлдэнэ.

- 3) Дотоодын квитанцид квитанц бичигчийн татвар төлөгчийн дугаар, харилцагч талын татвар төлөгчийн дугаар, сар өдөр, нийт авсан мөнгөний дүн гэсэн 4 төрлийн тоог заавал бөглөж бичнэ. Мөн 100000 төгрөгөөс дээш дүнтэй арилжааны хувьд барааны нэр, үйлчилгээний агуулгыг квитанцид бичнэ.
- 4) Үндэсний татварын албаны төв байгууллагад үлдэх дотоод арилжааны квитанцийг тухайн он дууссаны дараа, эсвэл нэг улирал өнгөрсний дараа тогтоосон хугацаанд татвар төлөгч харъяалагдах татварын албандаа өөрөө тушаана.
- 5) Дотоод арилжааны квитанцийг аж ахуйн нэгж байгууллага болон татвар төлөгч хувь хүн төдийгүй улс, орон нутгийн засаг захиргаа ч зарчмын хувьд бичиж болох бөгөөд дотоод арилжааны квитанцийн доод хэмжээг заан өгч болно. Тухайлбал, 5000 төгрөгөөс дээш дүн бүхий бараа, үйлчилгээ явуулсан татвар төлөгч төлбөр хүлээн авахдаа дотоод арилжааны квитанци заавал бичих жишээтэй.
- 6) Дотоод арилжааны квитанцийг бичээгүй тохиолдолд тухайн квитанцид бичигдэх ёстой байсан мөнгөн дүнгийн тодорхой хувь хэмжээгээр торгууль ногдуулна.
- 7) Дотоод арилжааны квитанцаар баталгаажаагүй татвар төлөгчийн зардал болон хөрөнгийн бүртгэл тооцоог татварын тооцоонд хүлээн зөвшөөрөхгүй.
- 8) Дотоод арилжааны квитанц бичих этгээд нь өөрт үлдэх квитанцийн хувийг 10 жил хадгалах үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд дотоод арилжааны квитанцид бичигдсэн байсан үнийн дүнгийн тодорхой хувь хэмжээгээр торгууль төлнө.

[2] Гадаад арилжаанд хэрэглэх квитанцийн системийн тухай

- 1) Гадаад арилжааны квитанцыг үндэсний татварын албаны төв байгууллагаас татвар төлөгчдөд үнэ төлбөргүйгээр тараах ба энэ нь тухайн жилдээ хүчинтэй байх бөгөөд гадаад арилжаанд хэрэглэгдэнэ. Энэхүү гадаад арилжааны квитанц нь (цаашид «гадаад квитанц» гэх) Монгол улсын болон гадаадын татвар төлөгч гэдгээс үл хамааран Монгол улсын татварын хууль тогтоомжид заасан татвар төлөгч хэн боловч ① Гадаад улсаас бараа бүтээгдэхүүн худалдан авч, ажил үйлчилгээ хүлээн аваад Монгол улсын татварын хуулийн дагуу тухайн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг зардал болон хөрөнгийн бүртгэлд тусгахдаа түүний баталгаа баримт болгон гаргах квитанц болон ② гадаадад бараа, бүтээгдэхүүн худалдах, ажил, үйлчилгээ үзүүлээд төлбөр хүлээн авсан тохиолдолд тухайн харилцагч байгууллагаас гаргуулж авах квитанцаас бүрдэнэ.
- 2) Гадаад квитанцийг 3 хувь үйлдэх бөгөөд нэгдэх хувийг үндэсний татварын албаны төв байгууллагад тушааж, хоёрдахь хувийг

татвар төлөгч өөрөө хадгалах ба гуравдахь хувийг харилцагч байгууллагад өгнө.

- 3) Гадаад квитанцид тухайн квитанц бичих этгээдийн татвар төлөгчийн дугаар, харилцагч байгууллагын тухай тэмдэглэл (улсын нэр, татвар төлөгчийн нэр, байршил, харилцах утас, факс, татварын албанд харьяалагддаг тохиолдолд тухайн татварын албанаас олгосон татвар төлөгчийн дугаар) арилжаа хийгдсэн огноо, төлбөр тооцоо хийгдсэн огноо, хүлээн авсан мөнгөн дүн, төлбөрийг хэсэгчлэн хийсэн тохиолдолд тухайн төлбөр хийгдсэн огноо болон хүлээн авсан мөнгөний дүн, арилжааны агуулга зэргийг бичнэ.
  - 4) Үндэсний татварын албаны төв байгууллагад өгөх гадаад квитанцийг тухайн жил дууссаны дараа, эсвэл нэг улирал дууссаны дараа тогтоосон хугацаанд харьяалагдах татварын албанд татвар төлөгч өөрөө тушаана.
  - 5) Гадаад квитанцид ажил гүйлгээний дүнгийн хэмжээ байхгүй.
  - 6) Гадаадаас худалдан авсан бараа бүтээгдэхүүн, хүлээн авсан ажил үйлчилгээ гадаад квитанцаар баталгаажаагүй тохиолдолд Монгол улсын татварын хууль тогтоомжид заасны дагуу түүнийг татварын тооцоонд оруулж тооцохгүй бөгөөд тухайн улсад бичигдсэн уг арилжаанд хамаарах квитанц байхгүй тохиолдолд мөн адил татварын тооцоонд оруулж тооцохгүй.
  - 7) Гадаад квитанцийг бичээгүй тохиолдолд тухайн квитанцид бичигдэх ёстой байсан мөнгөн дүнгийн тодорхой хувиар торгууль ногдуулна.
  - 8) Гадаад квитанцийг бичигч нь өөрт үлдэх хувийг 10 жил хадгалах үүрэгтэй. Энэ үүргийг биелүүлээгүй тохиолдолд тухайн квитанцид бичигдэх ёстой байсан мөнгөн дүнгийн тодорхой хувиар торгууль ногдуулна.
- [3] Үндэсний татварын албаны төв байгууллагын квитанцийн системд гүйцэтгэх үүрэг
- 1) Үндэсний татварын албаны төв байгууллага нь квитанцийн дугаарыг жил тутам компьютерын системээр дамжуулан хянах бөгөөд төв болон орон нутгийн татварын албадад хатуу хяналтын доор хуваарилна.
  - 2) Татварын алба нь харьяалагдах татвар төлөгчдөд квитанц хуваарилахдаа ямар татвар төлөгчид хэзээ, хаана хүлээлгэн өгсөн



тухай, мөн хүлээлгэн өгсөн квитанцийн дугаарыг холбогдох бүртгэлд тэмдэглэхийн зэрэгцээ татвар төлөгчийн биеийн байцаалтыг үндэслэн хүлээлгэн өгнө. Харьяалагдах татварын алба нь хүлээлгэн өгсөн квитанцын талаар татвар төлөгч тус бүрээр үндэсний татварын албаны төв байгууллагад шуурхай мэдээлнэ. Боломжтой бол харьяалагдах татварын алба өөр дээрээ дээрх мэдээллийг боловсруулан үндэсний татварын албаны төв байгууллага дахь татвар төлөгч тус бүрээр гаргасан мэдээллийн бааз болон квитанцийн мэдээллийн баазад шууд дамжуулах системийг нэвтрүүлэх хэрэгтэй.

- 3) Үндэсний татварын албаны төв байгууллагад тушаах квитанцийг квитанцийн мэдээллийн баазад оруулна. Хураан авсан квитанцаар татвар төлөгч бүрийн борлуулалттай холбогдох мэдээлэл болон харилцагч талын (Худалдан авалтанд хамаарах) мэдээлэл уг мэдээллийн баазад цугларна. Жишээ нь А татвар төлөгчөөс авсан квитанцаар дамжуулан тухайн татвар төлөгчийн квитанцийн мэдээлэлд орсон борлуулалтын орлогыг тооцох боломжтой бөгөөд А татвар төлөгчтэй харилцагч байгууллагуудад хамаарах худалдан авалт зэрэг арилжааны мэдээллийг тус тусын татвар төлөгчдийн мэдээллийн баазад компьютерээр оруулах боломжтой. Иймд А татвар төлөгч нь нэг жилд 10000 удаа өөр өөр харилцагчтай арилжаа хийсэн тохиолдолд хүлээн авсан квитанцаар дамжуулан А татвар төлөгчийн квитанцийн мэдээллийн бааз дахь 10000 арилжааны борлуулалтын орлогыг компьютерээр хялбар тооцож болно. Мөн А татвар төлөгчийн квитанцанд харилцагч татвар төлөгчийн дугаар бичигдэх тул компьютерээр 10000 татвар төлөгчийн мэдээллийн баазад А татвар төлөгчтэй хийсэн арилжаа, түүний огноо, мөнгөн дүнг оруулж бичих боломжтой. Мөн тухайн татвар төлөгчөөс авсан квитанцаар дамжуулан эдгээр 10000 татвар төлөгчийн дотроос татварт хамрагдах татвар төлөгчийн борлуулалтын орлогыг квитанцийн мэдээллийн баазад тооцон гаргахын хамт А татвар төлөгчтэй хийсэн худалдан авалтын дүн нь тухайн татвар төлөгчийн мэдээллийн баазад автоматаар орж тооцогдох тул түүний орлого нь квитанцийн системээр дамжин автоматаар тооцоологдох боломжтой болно.
- 4) Тайлангийн хугацаанд квитанц бичих татвар төлөгчийн жагсаалтанд өөрчлөлт орсон тохиолдолд төв, орон нутгийн татварын албад энэ тухай үндэсний татварын албаны төв байгууллагад мэдэгдэж тухайн татвар төлөгчийг бүртгэлээс хасах болон бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах, үлдэгдэл квитанцыг хурааж авах болон шинээр олгох арга хэмжээ авна.
- 5) Алдаатай бичих, баллах зэргээр хүчингүй болсон квитанцийг татварын албад хураан авч бүртгэлээс хасна.

### 1.2.2 Монголд квитанцийн систем нэвтрүүлэх боломжийн үндэслэл

- [1] Аж ахуйн нэгж байгууллага болон хувь хүн бизнесийн үйл ажиллагаа явуулж төлбөр хүлээн авсан тохиолдолд квитанц нь тухайн арилжаанд оролцогч талуудын арилжааг бүртгэж тэмдэглэсэн нотлох бичиг баримт болох тул тэд нар арилжаа хийх бүртээ квитанц гаргуулж авах явдалд нааштай хандана.
- [2] Монголд НӨАТ-ын падаан үндэсний татварын албаны төв байгууллагын баталсан загварын дагуу хэрэглэгдэж байгаа тул том татвар төлөгчийн зүгээс төдийлэн эсэргүүцэл гарахгүй.
- [3] Монгол улсын татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо цөөн бөгөөд бизнесийн үйл ажиллагааны цар хүрээ бусад оронтой харьцуулахад харьцангуй бага тул квитанцийн систем нэвтрүүлэхэд хялбар.
- [4] Монгол улсад квитанцийн системийг амжилттай нэвтрүүлж болох нэг үндэслэл нь татвар төлөгчийн нэгдсэн бүртгэлийн дугаар үйлчилж байгаа явдал юм. Аж ахуйн нэгж байгуулах болон бизнесийн үйл ажиллагаа явуулахад улсын бүртгэлд бүртгүүлэх үүрэг татвар төлөгчдөд ногддог бөгөөд энэхүү бүртгэлээр улсын бүртгэлийн албанаас татвар төлөгчийн байнгын дугаар олгодог. Хувь хүмүүсийн хувьд регистрийн дугаар (тухайн иргэний төрсөн он сар өдрийн ард тусгай дугаар бичигдсэн байх ба энэхүү дугаар нь мөн байнгын дугаар болно.) -ыг татвар төлөгчийн дугаар болгон ашиглаж буй тул эдгээр дугаарыг бүрэн ашиглаж татвар төлөгчид нэгдсэн дугаар олгох системд тулгуурлан квитанцийн системийг нэвтрүүлэх боломжтой. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчийн нэгдсэн бүртгэлийн системийг ашиглан одоо нүүрлээд байгаа далд эдийн засаг болон Монгол улсад явагдсан бүх арилжааны агуулгыг үндэсний татварын албаны төв байгууллага тухайн холбогдох төлбөрийг хүлээн авах үед нь мэдээллийн баазаараа дамжуулан олж мэдэх боломжтой.
- [5] Далд эдийн засагт татвараас гадуур үлдэж байгаа нуугдмал татвар төлөгчдийн тоо уг квитанцийн системийг нэвтрүүлснээр үлэмж буурах болно. Энэ нь татварын тооцоо хийхдээ аливаа төлбөрийг зардал болон хөрөнгийн бүртгэл тооцоонд оруулан тооцуулахын тулд харилцагч байгууллага нь квитанц бичиж өгөхийг зайлшгүй шаарддаг болох тул далд эдийн засаг дахь нуугдмал татвар төлөгчид ч мөн адил улсын бүртгэлийн албанд татвар төлөгчөөр бүртгүүлж, квитанц олгуулахаар татварын байгууллагад ханддаг болно.

### 1.2.3. Квитанцийн систем нэвтрүүлэх бэлтгэл арга хэмжээ

#### [1] Татвар төлөгчдөд квитанц тараах

Үндэсний татварын албаны төв байгууллагын хувьд татвар төлөгчдөд квитанцыг үнэ төлбөргүй тараах нь татварын байгууллагад үр ашигтай, мөн энэ нь татвар төлөгч бүрээрх үнэ цэнэтэй анхан шатны бичиг баримт болох тул үүнийг зайлшгүй хэрэгжүүлүүштэй юм. Үүнийг хэрэгжүүлэхэд төсөв мөнгөний асуудал гарч ирж болох хэдий ч хойшдын төсвийн орлогын өсөлтийг хангах үүднээс үүнээс өөр сонголт хийх арга зам байхгүй юм.

#### [2] Квитанц бичих татвар төлөгчдөд хийх хяналт шалгалтын тухай

Квитанц бичих татвар төлөгч эрхэлж буй ажил үйлчилгээндээ квитанц хэрхэн хэрэглэж хадгалж байгаа талаар татварын алба доор дурьдсан хяналт шалгалт хийх боломжтой. Мөн квитанцийг зохих журмын дагуу бичиж хадгалж байгаа эсэхийг шалгахад урьдчилан мэдэгдэлгүйгээр шалгалт хийх нь үр дүнтэй.

- ① График шалгалт
- ② Гэнэтийн шалгалт
- ③ Тайлан хүлээж авахад квитанци болон тайланд тусгагдсан үзүүлэлтүүдийг тулгах
- ④ Бусад хяналт шалгалттай нэгэн зэрэг квитанцийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх

#### [3] Татвар төлөгчийн татварын тооцоог хийх үед баримтлах зарчим Татвар төлөгчийн аливаа татварын тооцоог квитанцад тусгагдсан дүнд тулгуурлан тооцож гаргана.

#### [4] Квитанц хэрэглэж хэвшүүлэх нь Квитанцийн системийг амжилттай нэвтрүүлэхэд бараа бүтээгдэхүүн худалдан авч төлбөр хийх харилцагчийг квитанцийн системд хэрхэн үр ашигтайгаар хамруулах вэ гэдэг асуудал чухал юм. Дээр өгүүлсэнчлэн татвар төлөгч татварын тооцоо хийж зардал болон хөрөнгийн бүртгэл тооцоо хийхдээ квитанц авч хадгалах үүрэгтэй тул татвар төлөгчид квитанц хэрэглэж хэвших магадлал өндөр ч ердийн хэрэглэгчдийн хувьд энэ нь нэлээд хүндрэлтэй юм. Ердийн хэрэглэгчид нь татвартай ер нь харьцдаггүй тул тэдэнд квитанц гаргуулж авах сонирхол төдийлөн байдаггүй. Иймд хэрэглэгчдийн сэтгэхүйг хэрхэн өөрчилж чадахаас квитанцийн системийг амжилттай нэвтрүүлэх эсэх асуудал шалтгаална. Иймээс татвар төлөгчийг төлбөр хүлээж авах үедээ тухайн харилцагчаас тус арилжаанд хамаарах квитанцийг гаргуулж авдаг болгохын тулд ердийн хэрэглэгч гэх мэт төлбөр хийгчдийн хувьд квитанц гаргуулж авах нь ямар нэгэн байдлаар ашигтай байх тийм нөхцлийг

бүрдүүлж өгөх хэрэгтэй юм. Энэхүү асуудлыг шийдвэрлэх нэг арга зам бол татварын байгууллагад төлбөр хийгчийн авчирсан харилцагч байгууллагад үлдэх квитанцийг түүний мөнгөн дүн болон тоо хэмжээнд нь тохируулан тодорхой тогтоосон үнээр худалдаж авах арга болон татварын албанд тушаасан квитанцийн дугаараар улирал тутам эсвэл тогтмол хугацаанд хонжворт сугалаа гаргах аргыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх явдал юм. Хонжворт сугалаанд мөнгөн урамшуулал, эсвэл татварын өрөнд хурааж авсан эд хөрөнгийг олгож болох юм. Мөн төлбөр хийгч худалдан авалт хийхийн тулд арилжаа хийж буй тохиолдолд тухайн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тодорхой хэмжээний татварын хөнгөлөлт эдлүүлэх зэрэг урамшууллын механизмын талаар ч бас бодолцож үзэх хэрэгтэй.

[5] Квитанц хэрэглэх зарчим зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага Татвар төлөгч бараа бүтээгдэхүүн худалдах буюу ажил үйлчилгээ үзүүлж төлбөр хүлээж авсан хэдий ч квитанц бичээгүй нь татварын хяналт шалгалтаар илэрсэн тохиолдолд уг арилжаанд хамаарах бичиг баримтыг зохих журмын дагуу бүрдүүлээгүй гэж үзэн процессын хуулийн дагуу адил төрлийн арилжаа эрхлэгч татвар төлөгчийн орлого зардал болон бусад бодит тооцоонд үндэслэн жишиг татвар ногдуулна. Түүнчлэн тусгай зөвшөөрөл бүхий бараа бүтээгдэхүүн борлуулах, ажил үйлчилгээ үзүүлэх татвар төлөгч квитанц бичээгүй нь тогтоогдсон тохиолдолд татварын албанаас холбогдох зөвшөөрлийг хүчингүй болгох талаарх хүсэлтийг эрх бүхий яам газарт тавьдаг болох арга зам, квитанцийн системийг нэвтрүүлэх талаар судалж үзэх хэрэгтэй.

[6] Татвар төлөгчдөд квитанцийн системийг таниулах, суртчилах нь Квитанцийн системийг үр ашигтай нэвтрүүлэхийн тулд татвар төлөгчдөд зориулсан зөвлөмж боловсруулж, гарын авлага, товхимол тараах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар сурталчилгааг өргөн хүрээтэй явуулах хэрэгтэй.

#### **1.2.4 Квитанцийн системийн хэрэгжилтийн тал дээр нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ**

Квитанцийн системийг амжилттай нэвтрүүлэхийн тулд юуны өмнө зохих хууль тогтоомжид уг системийг нэвтрүүлэх тухай заалт оруулах хэрэгтэй. Татвар төлөгч болон иргэдэд квитанцийн системийн талаарх ойлголтыг төлөвшүүлэхэд тодорхой цаг хугацаа шаардагдана, мөн нөгөө талд УТЕГ-т квитанцийн системийг нэвтрүүлэхтэй холбогдсон техник болон программ хангамж гэх мэт компьютерын системжүүлэлтэд цаг хугацаа болон төсөв хөрөнгө шаардагдах тул квитанцийн системийг нэвтрүүлэх цаг хугацааг тодорхойлсны дараа квитанцийн хууль боловсруулах ажлыг нэн тэргүүнд шийдэх хэрэгтэй.

Квитанцийн системийг УТЕГ-ын дарга болон Санхүү эдийн засгийн сайдын тушаалаар хэрэгжүүлэх нь төдийлэн үр дүнд хүрэхгүй бөгөөд энэ нь нийт

улсын хэмжээнд, цаашилбал гадаад улс орныг хамарсан систем тул хуульчилж өгөх нь зүйтэй.

Квитанцийн системийг нэвтрүүлсний дараа ҮТЕГ дээрх компьютерын систем суулгалтаар квитанцийн мэдээллийн баазад мэдээлэл оруулах ажил хийгдэж байх хооронд татварын албад нь өөрт хадгалагдаж буй бусад татварын албаны харъяаллын татвар төлөгчдийн квитанцийн мэдээллийг татвар төлөгчийн хувийн хэрэгт гар ажиллагаагаар бүртгэхийн тулд баримт мэдээлэл солилцох цуглаан зохион байгуулах талаар судалж үзэх хэрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэхэд ямар нэгэн зардал гарахгүй бөгөөд татварын албад дээр цугларсан квитанц нь өөр татварын албаны харъяалах татвар төлөгчийнх байх тохиолдолд тус татварын алба тухайн баримтыг аваачиж өгөхийн хамт өөрийн харъяалах татвар төлөгчийн квитанцыг өөр татварын албанаас авах боломж бүрдэнэ. Улаанбаатар хотын татварын албад тогтмол хугацаанд энэхүү цуглааныг зохион байгуулбал нэг өдөр хүрэхгүй хугацаанд мэдээлэл бүрэн солилцох боломжтой. Орон нутгийн татварын албадтай мэдээлэл солилцохдоо ҮТЕГ, эсвэл Улаанбаатар хотын татварын газраар дамжуулж, харин аймгийн татварын албадын хооронд бол шуудангаар илгээхэд онцын хүндрэл гарахгүй гэж үзэж байна.

#### **1.2.5 Албан ёсны квитанци хэрэглэх журмын төсөл**

Албан ёсны квитанцийг хэрэглэх журмын жишээ болгож дараах хувилбарыг боловсруулав.

#### ***Борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд квитанци хэрэглэх журам (төсөл)***

##### ***1 дүгээр зүйл. Нийтлэг үндэслэл***

- 1.1. Энэхүү журмын зорилго нь борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд квитанци хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам нь татвар төлөгчийн худалдан авалт, борлуулалтыг баримтжуулан татварын тооцоог үнэн зөв хийлгэж хэвшүүлэх зорилгоор ажил, үйлчилгээний борлуулалтад квитанци хэрэглүүлэх, түүний хэрэглээнд татварын албанаас хяналт тавих дэг журмыг тогтооно.
- 1.3. Борлуулагч болон худалдан авагчийн нэр, бүртгэлийн дугаар, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, нэгжийн болон нийт үнийн дүн, он сар өдөр, хэрэв НӨАТ төлөгч бол ногдуулсан НӨТ зэрэг татвар ногдох орлогыг тодорхойлон татварын тооцоо хийхтэй холбогдсон мэдээллийг тусгасан татварын албанаас олгосон дугаар бүхий баримт бичгийг квитанци /цаашид "квитанци" гэх / гэнэ.

- 1.4. Монгол улсын нутаг дэвсгэр дээр бараа борлуулж, ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж буй бүх аж ахуйн нэгж, байгууллага болон иргэд /цаашид "татвар төлөгч" гэх/ 5000 төгрөгөөс дээш гарсан арилжаа бүртээ, НӨАТ төлөгчийн хувьд борлуулсан бараа, ажил, үйлчилгээ тус бүртээ квитанци хөтөлнө. Мөн орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчид татвар ногдуулах тухай хуулийн дагуу патентаар татварын тооцоо хийдэг татвар төлөгч мөн адил квитанци хэрэглэнэ.
- 1.5. Эрхэлж буй ажил үйлчилгээний нь онцлог байдлаас хамааруулан квитанци заавал хэрэглэх шаардлагатай татвар төлөгчдийн жагсаалтыг Үндэсний татварын албаны төв байгууллагын баталсаны дагуу татварын албаны төв, орон нутгийн байгууллагууд шийднэ.

## **2 дугаар зүйл. Квитанци гаргах**

- 2.1. Квитанцийг хавсралт загварын дагуу Үндэсний татварын албаны төв байгууллага нэгдсэн журмаар хэвлүүлэн төв орон нутгийн татварын албадад хүргүүлнэ.
- 2.2. Татварын албад нь тухайн нутаг дэвсгэртээ квитанци хэрэглэх шаардлагатай татвар төлөгчдөд квитанцийг үнэгүй өгнө.
- 2.3. Татварын албад нь тухайн нутаг дэвсгэртээ квитанци хэрэглэх шаардлагатай татвар төлөгчдийн жагсаалтыг улирал бүр шинэчлэхийн зэрэгцээ квитанцийн хэрэгцээт захиалгаа гарган Үндэсний татварын албаны төв байгууллагад ирүүлж байна.
- 2.4. Тайлант хугацаанд квитанц хэрэглэх шаардлагатай татвар төлөгчдийн жагсаалтад өөрчлөлт орох бол татварын албад нь энэ тухай Үндэсний татварын албаны төв байгууллагад мэдэгдэн зохих зөвшөөрөл авсаны үндсэн дээр тухайн татвар төлөгчийг жагсаалтаас хасах буюу жагсаалтад нэмэх, хэрэглээгүй байгаа квитанцийг хураан авах буюу шинээр олгох арга хэмжээ авна.
- 2.5. Татвар төлөгчийн хүсэлтийн дагуу тухайн татвар төлөгч квитанци хэрэглэх шаардлаггүй гэж төв орон нутгийн татварын албад үзсэн тохиолдолд татварын албад нь энэ тухай Үндэсний татварын албаны төв байгууллагад мэдэгдэн зохих зөвшөөрөл авсаны үндсэн дээр тухайн татвар төлөгчийг жагсаалтаас хасах буюу хэрэглээгүй квитанци үлдсэн бол хураан авах арга хэмжээ авна. Бүртгэлээс хасагдсан татвар төлөгчийн энэхүү хүсэлт болон холбогдох бичиг баримтыг татварын алба хадгална.

## **3 дугаар зүйл. Квитанцинд тавих шаардлага**

- 3.1. Квитанци нь хавсралтад заасан загвартай байна.
- 3.2. Квитанц нь татвар төлөгчийн дугаартай байх ба дугаар бүрийн өмнө татварын албадын ялгах кодыг тавьсан байна.
- 3.3. Квитанцийн дугаар давхардахгүй байна.
- 3.4. Квитанцийг 3 хувь үйлдэх бөгөөд нэгдэх хувь нь үндэсний татварын албаны төв байгууллагад, хоёрдахь хувь нь харилцагч талд, гуравдахь хувь нь татвар төлөгч өөрт нь үлдэнэ.

- 3.5 Квитанцийг жил бүрийн эхэнд шинэчлэнэ. Иймд квитанци нь тухайн тогтоосон хугацааны дотор хүчинтэй байна.
- 3.6 Квитанцинд дор дурдсан зүйлийг бичнэ.
- ① Борлуулагчийн нэр, хаяг, аж ахуйн нэгжийн нэр, холбоо барих хаяг, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар
  - ② Квитанци бичсэн он сар өдөр (арилжаа хийгдсэн өдөр болон квитанци бичсэн өдөр зөрөх тохиолдолд арилжаа хийгдсэн он сар өдрийг тэмдэглэнэ.)
  - ③ Худалдан авагчийн нэр, хаяг, бүртгэлийн дугаар
  - ④ Борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нийт үнийн дүн

#### **4 дүгээр зүйл. Квитанци хэрэглэх шаардлагатай татвар төлөгчийн үүрэг**

- 4.1. Тусгай хүлээн зөвшөөрсөн тохиолдлоос бусад 5000 төгрөгөөс дээш үнэ бүхий бараа худалдан борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх тухай бүрдээ квитанцийг худалдан авагчид бичиж өгнө. Харин НӨАТ төлөгч нь бүх борлуулалтандаа квитанци бичнэ.
- 4.2. Квитанци хэрэглэх үүрэг хүлээсэн татвар төлөгч харъяалагдах татварын албанд бүртгүүлж квитанцийн маягтыг хүлээж авна.
- 4.3. Татвар төлөгч квитанцийн бичилтийг энэ журмын 3 дугаар хэсэгт заасан агуулгын дагуу гаргацтай, үнэн зөв хийнэ.
- 4.4. Татвар төлөгч өөрт үлдэх квитанцийн хувийг худалдан авагчид өгсөнөөсөө хойш 10 жил хадгална.
- 4.5. Татвар төлөгч нь хяналт шалгалтын үеэр квитанцийн өөрт үлдэх хувь болон бусад харилцагч татвар төлөгчээс хүлээж авсан бүх квитанцийг татварын албанд шалгуулна.
- 4.6. Татвар төлөгч нь тухайн улиралд өөрт хадгалагдаж байгаа бүх квитанцийг улирал бүрийн эхний сарын 15-ний өдрийн дотор татварын албанд тушаана.
- 4.7. Үлдэгдэл квитанцийг дараа оны 1 сарын 15-ний өдрийн дотор харъяалагдах татварын албанд тушаана.

#### **5 дугаар зүйл. Квитанцийг хэрэглэх**

- 5.1. Татвар төлөгч 5000 төгрөгийн үнийн дүн бүхий бараа худалдан борлуулах, ажил үйлчилгээ үзүүлэх тухай бүрдээ худалдан авагчид квитанци бичнэ.
- 5.2. Татвар төлөгч нь бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх бүрдээ квитанцийг загварт заасны дагуу 3 хувь үйлдэж нэг хувийг худалдан авагчид, нэг хувийг өөрийн бүртгэлд, үлдэх хувийг харьяалах татварын албанд өгөхөөр хадгалах ба энэ хувь нь тухайн татвар төлөгч татвар ногдох орлогоо үнэн зөв тодорхойлсон эсэхэд татварын албанаас хяналт тавих үндсэн баримт бичиг болно.

Татвар төлөгч нь буруу бичих, гэмтээх гэх мэт замаар хүчингүй болгосон квитанциа харьяалах татварын албанд буцаан өгч нийт тооноос хасуулна.

**6 дугаар зүйл. Квитанцийн хэрэглээнд хяналт тавих болон татварын албаны эрх, үүрэг**

6.1. Татвар төлөгчөөс ажил, үйлчилгээндээ квитанци хэрэглэж байгаа байдалд татварын албад дараахь байдлаар хяналт тавина. Үүнд

- а/ төлөвлөгөөт шалгалт хийх
- б/ гэнэтийн шалгалт хийх
- в/ квитанцийн үлдэгдлийг тогтоох
- г/ худалдан авагч хувь хүмүүсийн дунд квитанцийн дугаараар хонжворт сугалаа явуулах, худалдаж авах

**7 дугаар зүйл. Худалдан авагчийн үүрэг**

7.1. Татвар төлөгч нь 5000 төгрөгийн үнийн дүнгээс дээш бараа худалдан авах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ авах тухай бүрдээ зохих ёсны бичилтүүд бүрэн хийгдсэн квитанцийг заавал гаргуулан авч 10 жилийн хугацаанд хадгална.

7.2. Татвар төлөгч хүлээж авсан квитанцан дээр дараах зүйлийг заавал бичүүлнэ.

- ① Борлуулагчийн нэр, хаяг, аж ахуйн нэгжийн нэр, холбоо барих хаяг, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар
- ② Квитанци бичсэн он сар өдөр (арилжаа хийгдсэн өдөр болон квитанци бичсэн өдөр зөрөх тохиолдолд арилжаа хийгдсэн он сар өдрийг тэмдэглэнэ.)
- ③ Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар (хувь хүний хувьд регистрийн дугаар)
- ④ Борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нийт үнийн дүн

**8 дугаар зүйл. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

Энэ журам болон холбогдох бусад хууль, тогтоол, журмуудыг зөрчсөн татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дараахь тохиолдолд дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ.

8.1 Татварын хяналт шалгалтын явцад 5000 төгрөгийн үнийн дүнгээс дээш борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээндээ квитанци бичээгүй нь тогтоогдвол татвар төлөгчтэй ойролцоо төрлийн борлуулалт хийдэг татвар төлөгчийн орлого, зарлагын буюу бусад бодит тооцоонд үндэслэн ногдох татварын хэмжээг татварын албанаас жишгээр тодорхойлно. Мөн хүндэтгэх шалтгаангүйгээр



квитанци бичээгүй тохиолдолд тухайн арилжааны үнийн дүнгийн 5-50 хувиар торгууль ногдуулна. Энэ тухай шийдвэрийг харъяалагдах татварын албаны дарга гаргана.

- 8.2 Татвар ногдох орлого бүхий татвар төлөх үүрэг хүлээсэн татвар төлөгч энэ хуулийн дагуу татварын тооцоо хийх баримт болох квитанцийг бичих буюу хүлээн авч заасан хугацаанд хадгалаагүй нь илэрсэн тохиолдолд тухайн квитанцинд бичигдэх ёстой байсан үнийн дүнгийн 5-50 хувиар торгууль ногдуулна. Энэ тухай шийдвэрийг харъяалагдах татварын албаны дарга гаргана.
- 8.3 Татвар төлөгч 5000 төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан боловч холбогдох квитанци бичүүлж аваагүй тохиолдолд худалдан авагчийн татварын тооцоог хийх үед нийт татвар ногдуулах орлогоос квитанцаар баталгаажаагүй худалдан авалтыг өртөгт оруулж тооцохгүй.
- 8.4 Тусгай зөвшөөрөл бүхий бараа борлуулж, ажил, үйлчилгээ гүйцэтгэдэг татвар төлөгч квитанци бичилгүйгээр ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн бол холбогдох тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах хүсэлтийг татварын албанаас холбогдох яам, газруудад тавьж шийдвэрлүүлнэ.

### **9 дүгээр зүйл. Журам хүчин төгөлдөр болох**

Энэхүү журмыг 2001 оны... дүгээр...сарын...ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.